



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2021 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/15

Улаанбаатар хот

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 дугаартай “Эрх, үүрэг шилжүүлэх тухай” тушаалын 5 дугаар хавсралт, 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9, 2021 оны Б/08 дугаартай “Албан үүрэг түр орлон гүйцэтгүүлэх тухай” тушаал, Нийслэл дэх Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн 2021 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн хурлын саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитын / НАГ-2021/06-1-ШТА-ГА/ тайлан, албан шаардлагыг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж, зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг бүрэн хангуулж, дүнг 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хариу мэдэгдэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч /Д.Сумьяабазар/, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар /Г.Энхтайван/, “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ /Б.Мөнхбат/-т тус тус зөвлөсүгэй.

3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2021 оны 4 дүгээр улиралд гаргаж танилцуулахыг Аудитын гуравдугаар хэлтэс /Э.Мөнхмандах/-т үүрэг болгосугай

4. Тайланг Үндэсний аудитын газар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-т тус тус хүргүүлсүгэй.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



М.ЭРДЭНЭЖАРГАЛ



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН






Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөлттэй, үр нөлөөтэй хэрэгжүүлж, тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.



АУДИТЫН СЭДЭВ: УЛСЫН ТӨСВИЙН 2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ

Улаанбаатар хот
2021 он



Аудитын тайланг бэлтгэсэн:	Товчилсон үг	3
Нийслэл дэх Төрийн аудитын газар	Хүснэгтийн жагсаалт	4
Аудитын III хэлтэс	Хавсралтын жагсаалт	4
Хэлтсийн дарга, аудитын менежер:  Э.Мөнхмандах	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	5
Аудитын менежер:  Л.Саранбаатар	Ерөнхий мэдээлэл	6
Ахлах аудитор:  Б.Билэгт	Бүлэг 1. А. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй байна уу?	7
Аудитор:  Б.Билэгт	А.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөх зохистой арга хэмжээг авч байна уу?	7-9
Гэрээт ажилтан:  З.Болд	А.3. Төсөл, арга хэмжээг үр ашигтай төлөвлөх бодлогын хэрэгжилтийг хангуулсан уу?	9-13
 П.Энхбаяр	Бүлэг 2. Б.Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байна уу?	14
Хаяг: УБ хот, Сүхбаатар дүүрэг, Соёлын Төв өргөө "Г" корпус, Утас: 327787	Б.1. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулагдсан уу?	14-22
Тайланг НТАГ-ын http://www.audit.mn/ веб сайтаас үзнэ үү.	Б.2. Захиалагч гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангуулсан уу?	22-26
	Б.3. ТАХ-ний гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн үү?	27-29
	Б.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын тухайн жилд батлагдсан санхүүжилтийг бүрэн ашиглах зорилгоор Засгийн газраас гаргасан шийдвэр үр дүнтэй байна уу?	29-31
	Аудитын дүгнэлт	32
	Аудитын зөвлөмж	33
	Ирүүлсэн санал, тайлбар	34-35
	Хавсралтууд	36-46



Товчилсон үг

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
БНД	Багануур дүүрэг
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БСШУСС	Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайд
БШУСС	Боловсрол, шинжлэх ухаан спортын сайд
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
БХД	Багахангай дүүрэг
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗГ	Засгийн газар
ЗД	Засаг дарга
ЗТХС	Зам тээвэр, хөгжлийн сайд
ЗАА	Захирагчийн
МУ	Монгол Улс
НАЗХГ	Нийслэлийн Авто замын хөгжлийн газар
НБГ	Нийслэлийн Боловсролын газар
НД	Налайх дүүрэг
НЗД	Нийслэлийн Засаг дарга
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НИТХ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НМХГ	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар
НӨАУГ	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
НХААГ	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар
НХБХГ	Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар
НХОГ	Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТШӨХ	Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТӨӨЗ	Тендерт оролцогчдод өгөх зөвлөмж
СБД	Сүхбаатар дүүрэг
СХД	Сонгинохайрхан дүүрэг
УБ	Улаанбаатар
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХААА	Худалдан авах ажиллагааны алба
ХУД	Хан-Уул дүүрэг
ХХААХҮС	Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
ЧД	Чингэлтэй дүүрэг
ЭМС	Эрүүл мэндийн сайд



Хүснэгтийн жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
Хүснэгт 1	Хөтөлбөрүүдэд тусгагдсан байдал	7
Хүснэгт 2	НЗД-аас санал хүргүүлсэн ТАХ	8
Хүснэгт 3	НЗД-ын саналаар төсөвт батлагдсан ТАХ	8
Хүснэгт 4	Тухайн онд санхүүжих дүнг дутуу баталсан ТАХ	11
Хүснэгт 5	Хөрөнгө оруулалтын бус шинж чанартай ТАХ	12
Хүснэгт 6	Нийслэл, дүүргийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх боломжтой ТАХ	12-13
Хүснэгт 7	ТАХ-ний худалдан авалт	14
Хүснэгт 8	ТЕЗ-аас ТАХ-ний эрхийг шилжүүлэхэд зарцуулсан хугацаа	15
Хүснэгт 9	НЗД-аас ТАХ-ний эрхийг шилжүүлэхэд зарцуулсан хугацаа	16
Хүснэгт 10	2-3 удаа зохион байгуулсан ТАХ	17
Хүснэгт 11	ТАХ-ний худалдан авалтын судалгаа	18
Хүснэгт 12	“НХОГ” ОНӨААТҮГ -аас ХАА зохион байгуулсан ТАХ	21
Хүснэгт 13	ТАХ-ний гэрээний хэрэгжилт	22
Хүснэгт 14	Гүйцэтгэгч байгууллагаас шалтгаалж гэрээний хугацаандаа дуусаагүй ТАХ	23
Хүснэгт 15	2020 онд ТЕЗ-аас нийслэлээр дамжин санхүүжүүлсэн дүн	28
Хүснэгт 16	Гүйцэтгэлд үндэслээгүй олгосон санхүүжилтийн задаргаа	28
Хүснэгт 17	Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан хөрөнгийн дүн	30

Хавсралтын жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
Хавсралт 1	Тодотголоор хасагдсан зураг төсөвгүй ТАХ	34
Хавсралт 2	Тухайн онд санхүүжих дүнг дутуу баталсан ТАХ	34-35
Хавсралт 3	ТАХ-ний төсөвт өртөг нь 88.0 сая төгрөгөөс бага ажлын жагсаалт	35-38
Хавсралт 4	Газрын зөвшөөрөл, зураг төсөв, зургийн даалгавар, ажлын даалгавар, техникийн тодорхойлолт боловсруулаагүй байсан зэрэгтэй холбоотойгоор хугацаа хойшилсон ТАХ	38-41
Хавсралт 5	Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэйгөөр ХАА -г зохион байгуулсан ТАХ-ний жагсаалт	41-42
Хавсралт 6	Санхүүжилтийг гүйцэтгэгчид дутуу олгосон ТАХ -ний жагсаалт	42-43
Хавсралт 7	НӨАУГ бүртгэсэн хөрөнгө оруулалтын ажлын жагсаалт	43-44



Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудитын зорилт	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан Үндэсний аудитын газраас гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн хийв. Аудитын зорилт Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт аудит хийж дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд чиглэгдсэн. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэсэн. Үүнд, - Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй байгаа эсэх; - Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байгаа эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Аудитыг НЗДТГ, УБ хотын ЗАА, НАЗХГ, НБГ, НХААГ, НӨАУАГ, “НХОГ” ОНӨААТҮГ болон холбогдох бусад газруудыг хамруулан гүйцэтгэлээ.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУС 300, 3000-3100 үндэслэн боловсруулсан гүйцэтгэлийн аудитын журмыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага хийх, асуулга, судалгаа авах, мэдээ, тайланг судалж, санхүүгийн тайлангийн болон нөхцөл байдлын шинжилгээ хийх зэргээр аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, ажлын баримт боловсруулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг 3 дугаар хэлтсийн дарга Э.Мөнхмандах хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Л.Саранбаатар хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Билэгт, аудитор З.Болд, Гэрээт ажилтан П.Энхбаяр нар гүйцэтгэв. Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрөөс 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл хэрэгжүүлэв.
Аудитын явцад үүссэн хүндрэл бэрхшээл	Тус аудитын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийг УАГ -аас 2021 оны 3 дугаар сарын 11-ний өдөр ирүүлж, дэд төлөвлөгөөг 2021 оны 3 дугаар сарын 12-ны өдөр батлуулж аудитыг эхлүүлсэн . Дээрх хугацаанаас өмнө аудитыг хийхэд шалгагдагч байгууллагуудаас аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг шаардах, баримт материал ирүүлэхгүй байх зэрэг хүндрэл үүссэн. 2021 оны 3 дугаар сарын 12-ны өдрөөс гүйцэтгэлийн үе шатны ажлыг эхлүүлж, гүйцэтгэлийн үе шат 13 хоног үргэлжилж цаг хугацааны хувьд хүрэлцээгүй байсан . “Covid-19” цар тахлын хатуу хөл хорионы үеийн дэглэмтэй холбогдуулан БНД, НД, БХД-т хэрэгжсэн ТАХ-ний хэрэгжилтийн байдалтай газар дээр нь тулган баталгаажуулалт хийх боломжгүй байсан.



ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2020 оны Төсвийн тухай хуульд батлагдсан улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад тусгагдсан ажлаас Нийслэл, дүүргийн ЗД-д 351,713.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 174 ТАХ-г зохион байгуулах, хэрэгжүүлэх эрхийг шилжүүлсэн.

ТЕЗ-даас эрх шилжүүлэхдээ хуульд батлагдсан ТАХ-ний төсөвт өртгийг задлах, хуваах, багцлах байдлаар шилжүүлсэн, мөн НЗД-аас дээрх байдлаар задалж харьяа газрууддаа эрхийг нь шилжүүлжээ. Тухайлбал: БХБС-аас Төсвийн тухай хуулийн хавсралтын XI.1.59-д тусгагдсан ТАХ-г 15 болгон задалж шилжүүлсэн. НЗД-аас дээрх 15 ТАХ-г 51 болгон задалсан байдлаар шилжүүлсэн нь хуульд батлагдсан ТАХ-ний тоон дүнг нь өсгөж байна.

ТАХ-г дээрх байдлаар задалж нийслэлд хэрэгжих ТАХ-ний тоон дүн нь 253 ТАХ болсон. Үүнээс 138,779.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 209 ТАХ нь 2020 онд шинээр хэрэгжих, 212,934.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 44 нь өмнөх онуудаас хэрэгжсэн ТАХ байна.

Шинээр хэрэгжих 209 ТАХ-ээс 2020 онд ХАА-г зохион байгуулж, үр дүн гарсан 148 ТАХ байна. Харин зураг төсөв, ажлын даалгаваргүй байсан, хөрөнгө нь татагдсан, тендер зохион байгуулах ажил явагдаж байгаа зэргээс шалтгаалан 61 ТАХ-ний ХАА тухайн онд хэрэгжээгүй байна.

Өмнөх оноос дамжин хийгдсэн болон 2020 онд шинээр эхэлсэн 296,504.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй 205 ТАХ-д нийт 11 газраас захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн байна.

2020 онд 41,888.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй 73 ТАХ хэрэгжиж дууссан, 254,615.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй 132 ТАХ 2021 онд үргэлжлэн хэрэгжиж байна.

Аудитын түүврийг хийхдээ МУ-ын Ерөнхий аудиторын 2018 оны А/351 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Гүйцэтгэлийн аудитад түүвэрлэлтийг ашиглах” зааврын дагуу эх олонлогийг бүхэлд нь хамруулах үүднээс 2020 онд хэрэгжсэн ТАХ-ний төсөвт өртөг б олон төрөл тус бүрээс хамруулсан. Үүнд:

- 2020 онд худалдан авах ажиллагаа зохион байгуулсан 127,125.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 148 ТАХ-ээс 113,325.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 114 ТАХ буюу 77.0%-ийг ХАА-ны түүвэрт;
- Хэрэгжиж дууссан 41,888.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 73 ТАХ-ээс 32,976.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 40 ТАХ буюу 54.8%-ийг гүйцэтгэлийн түүвэрт;
- 2020 онд санхүүжилт олгосон 247,017.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 141 ТАХ-ээс 237,509.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 102 ТАХ буюу 72.3%-ийг санхүүжилтийн түүвэрт тус тус хамруулсан.



БҮЛЭГ 1. А. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ТОГТОЛЦОО ҮР НӨЛӨӨТЭЙ БАЙНА УУ?

А.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөх зохистой арга хэмжээг авч байна уу?

УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоолоор ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2019 оны 54 дугаар тогтоолоор МУ-ын Эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг баталсан байна. Мөн Төсвийн тухай хуулийн 10.1.5, 28.8, 29.3.2, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 11.2-д заасныг тус тус үндэслэн ЗГ-ын 2018 оны 140, 2019 оны 290 дугаар тогтоолоор Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг баталжээ.

А.1.1. Жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн хөтөлбөр, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2020 онд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсвийн хүрээний мэдэгдэл болон төсвийн хязгаартай нийцэж байна уу?

ТЕЗ-даас НЗД-д эрх шилжүүлсэн 2020 онд шинээр хэрэгжүүлэх 174 ТАХ нь ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, МУ -ын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, МУ -ын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт дараах байдалтай тусгагджээ.

Хүснэгт 1. Хөтөлбөрүүдэд тусгагдсан байдал

№	Нэр	Үүнээс		Тусгагдаагүй тоо
		Шууд туссан ТАХ-ний тоо	Ерөнхий байдлаар туссан ТАХ-ний тоо	
1	ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр	0.0	160	14
2	МУ-ын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	0.0	57	117
3	МУ-ын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр	2	81	91

ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 92.0 % буюу 160, МУ-ын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд 32.8 % буюу 57, МУ-ын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт 46.6 % буюу 81 ТАХ нь ерөнхий байдлаар тусгагдсан бол дээрх 3 хөтөлбөрт ш ууд нэршлээр тусгагдсан 2 ТАХ байна.

Төсвийн тухай хуулийн 4.1.8¹, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 5.1.3.², 11.1.1³-д заасны дагуу холбогдох ТЕЗ-нь өөрсдийн эрх мэдлийн хүрээний төсвийн хязгаар, төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулж батлуулдаг учир нийслэлд эрх шилжсэн ажлын хувьд төсвийн хүрээний мэдэгдэл болон төсвийн хязгаартай нийцэж байгаа эсэхийг дүгнэх боломжгүй байна.

Дүгнэлт: 2020 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр жагсаалтад батлагдсан ТАХ-ний 57.1% нь хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичгүүдтэй нийцсэн байна.

¹ "жилийн төсвийн хязгаар" гэж төсвийн тусгай шаардлага, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсөв боловсруулахад баримтлах орлогын доод хэмжээ, зарлагын дээд хэмжээг;

² төсвийн тусгай шаардлагад нийцүүлэн баталсан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлээр төсвийн бодлогыг тодорхойлж, түүнд үндэслэн аль ч шатны төсвийн эрх захирагч нь төсвийн тусгай шаардлагыг хангасан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлт болон түүнд нийцүүлэн баталсан төсвийн хязгаарт багтаан төсвийн төслөө зохиох;

³ дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөл, төсвийн тодотголын төсөл болон жилийн төсвийн хязгаарыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх;



А.1.2. Жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээ салбарын бодлого, ТЕЗ-дын саналд үндэслэсэн үү?

НЗД-аас 2019 оны 08 дугаар сарын 01 өдрийн 01/3406-01/3415 тоот албан бичгээр ЗГХЭГ-ын дарга, БСШУСС, БОАЖС зэрэг 12 ТЕЗ-д 2020 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ -ний жагсаалтад тусгуулах нийт 3,746,457.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 701 ТАХ-ний саналыг хүргүүлжээ.

Хүснэгт 2. НЗД-аас санал хүргүүлсэн ТАХ

№	ТЕЗ нэр	Төсөл, арга хэмжээний тоо			Төсөвт өртөг	2020 онд санхүүжих дүн
		Нийт	Он дамжих	Шинэ		
1	МУШС	7	-	7	27,203.0	13,754.0
2	ЗГХЭГ	20	1	19	51,648.5	41,654.0
3	БОАЖС	22	-	22	90,928.2	79,728.2
4	ХЗДХС	22	-	22	20,794.7	15,494.7
5	БХБС	114	14	100	674,348.5	394,290.4
6	БСШУСС	258	44	214	547,756.9	369,565.1
7	ЗТХС	118	2	116	1,682,468.4	886,515.3
8	ХХААХҮС	19	1	18	302,053.4	113,537.0
9	УУХҮС	5	-	5	20,157.9	9,871.2
10	ХНХС	10	2	8	15,754.3	13,304.3
11	ЭМС	60	-	60	96,880.9	56,019.9
12	ЭХС	46	1	45	216,462.9	127,852.9
	Нийт	701	65	636	3,746,457.6	2,121,587.0

Санал хүргүүлсэн дээрх 701 ТАХ-ээс 30,044.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 ТАХ-г 2020 оны Төсвийн тухай хуулийн хавсралтаар баталсан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ажлын жагсаалтын БШУСС-ын багцад баталжээ.

Хүснэгт 3. НЗД-ын саналаар төсөвт батлагдсан ТАХ

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		НЗД-ын саналд туссан дүн		Батлагдсан	
		Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	2020 онд санхүүжих	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
1	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор /УБ, ХУД, 13 дугаар хороо/	2020	2021	3,500.0	3,500.0	3,000.0	300.0
2	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /УБ, БГД, 23 дугаар хороо/	2020	2021	3,500.0	3,500.0	3,315.0	300.0
3	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /УБ, БЗД, 20 дугаар хороо/	2020	2021	3,500.0	3,500.0	2,832.1	300.0
4	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /УБ, БЗД, 23 дугаар хороо/	2020	2021	3,500.0	3,500.0	3,500.0	300.0
5	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /УБ, СХД, 24 дүгээр хороо/	2020	2021	3,500.0	3,500.0	3,500.0	300.0
6	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /УБ, СХД, 7 дугаар хороо/	2020	2021	3,500.0	3,500.0	3,500.0	300.0
7	Сургуулийн спорт заалны өргөтгөлийн барилга /УБ, СХД, 105 дугаар сургууль/	2020	2020	1,060.0	1,060.0	1,060.0	1,060.0
8	Сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /УБ, НД, 7 дугаар хороо/	2020	2021	3,500.0	3,500.0	3,300.0	300.0
9	Цэцэрлэгийн барилга /УБ, СБД, 149 дүгээр цэцэрлэг, 1 дүгээр корпус/	2020	2021	1,589.1	1,589.1	1,687.5	160.0
10	Цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих /УБ, БЗД, 16 дугаар хороо, 40 дүгээр сувилал цэцэрлэг/	2020	2021	3,780.1	3,780.1	3,780.0	1,000.0
11	"Боловсрол" цогцолбор сургуулийн барилгын их засвар /УБ, БНД/	2020	2020	261.0	261.0	250.0	250.0
12	Цэцэрлэгийн барилгын их засвар /УБ, БНД, 139 дүгээр цэцэрлэг/	2020	2020	225.2	225.2	320.0	320.0
	Нийт			31,415.4	31,415.4	30,044.6	4,890.0



Дээрх байдлаар НЗД-аас санал болгосон ТАХ-г хуульд баталснаар ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.2, 3.2.3-т тусгагдсан “Хүүхэд бүр цэцэрлэгт хамрагдах боломжийг бий болох, 3 ээлжтэй сургуулийг 2 ээлжид шилжүүлэх” зорилт биелэгдэж, сургууль цэцэрлэгийн хүртээмж сайжрах сайн талтай байна.

Дүгнэлт: НЗД-аас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх санал хүргүүлсэн ТАХ-ний 2.0%-ийг улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлын жагсаалтад тусган баталжээ.

А.3. Төсөл, арга хэмжээг үр ашигтай төлөвлөх бодлогын хэрэгжилтийг хангуулсан уу?

2020 оны Төсвийн тухай хуульд батлагдсан улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад шууд болон төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад бөөн дүнгээр тусгагдсан ТАХ-ээс 351,713.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 253 ТАХ-г нийслэлд зохион байгуулж, хэрэгжүүлэх эрхийг холбогдох ТЕЗ-аас Нийслэлийн засаг даргад шилжүүлжээ.

Эдгээр 253 ТАХ-ээс 138,779.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 209 ТАХ нь 2020 онд шинээр хэрэгжих, 212,934.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 44 нь өмнөх онуудаас хэрэгжсэн ТАХ байна.

Шинээр хэрэгжих 209 ТАХ-ээс 2020 онд ХАА-г зохион байгуулж, үр дүн гарсан 148 ТАХ байна. Харин зураг төсөв, ажлын даалгаваргүй байсан, хөрөнгө нь татагдсан, тендер зохион байгуулах ажил явагдаж байгаа зэргээс шалтгаалан 61 ТАХ-ний ХАА тухайн онд хэрэгжээгүй байна.

Мөн уг 61 ТАХ-ээс төсвийн тухай хуульд тодотгол хийсний дагуу 34 ТАХ-г хассан байна.

А.3.1. Шинээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө төсөвлөлтийн шаардлагыг хангуулсан уу?

Төсвийн тухай хуульд шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө төсөвлөлтийн шаардлагыг хангасны дараа төсөвт тусгахаар заажээ.

НЗД-д эрх шилжсэн 2020 онд шинээр хэрэгжих 138,779.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 209 ТАХ-ээс 113,325.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 114 ТАХ-г түүвэрлэн төсөвлөлтийн шаардлага хангуулсан эсэхийг шалгахад зураг төсөв шаардлагатай 62 ТАХ байна. Үүнээс 42 ТАХ нь баталгаажсан зураг, төсөвгүй Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4⁴-т заалтыг зөрчсөн байна. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-г баталж хэрэгжүүлснээр байгаль орчинд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй зарим асуудал үүссэн байна. Үүнд:

- *Агро паркийн эко сургалтын төвийн барилга, 300 суудал / УБ хот БГД, 20 дугаар хороо, Төсөвт өртөг: 2,500.0 сая төгрөг/*
НЗД-ын 2015 оны А/723 дугаар захирамжтай, 18634307692000 нэгж талбарын дугаартай. БГД-ийн 20-р хорооны нутаг дэвсгэрт ТЭЦ-4 станцын гудамжинд цэцэрлэгт хүрээлэн, мод үржүүлгийн зориулалттай газрын зориулалтыг өөрчлөн, архитектур төлөвлөлтийг зөөвөрлөх боломжтой түр барилга хэлбэрээр төлөвлөсөн. Тус барилга нь БОАЖХС, БХБС-ын 2015 оны А-230/127 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн

⁴ 29.4. Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.



хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам"-ын 3.9⁵ дэх заалтыг зөрчин баригдсан тул холбогдох газраас ус хангамж, ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд холбох техникийн нөхцөлийг олгоогүй байна.

Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын бүсэд газрын зориулалтыг өөрчлөн сургалтын төвийн түр барилга баригдсанаар усны эх үүсвэр эрүүл ахуй аюулгүй байх нөхцөл алдагдахад хүрч байна. Сургалтын зориулалтаар хориглолтын бүсэд баригдсан барилга байгууламж нь хүрээлэн буй орчны тэнцвэрт харьцаа, аюулгүй байдалд нөлөөлөх эрсдэлтэй тул холбогдох мэргэжлийн байгууллагаар хянуулж дүгнэлт гаргуулах нөхцөл үүссэн байна.

Төсвийн тухай хуулийн 22.2⁶, 22.2.3⁷-т заасан төсвийн эдийн засгийн ангилал, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам" -ын 2.1.1⁸-т заасныг баримтлалгүйгээр барилга, байгууламжийн ангилалд их засвар, тоног төхөөрөмж авах ажлыг нэгтгэн төлөвлөж батлуулжээ. Үүнд:

- Хүүхдийн шүдний кабинет / УБ хот ЧД, 39, 57 дугаар сургууль/-ийн 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тоног төхөөрөмж худалдан авах ажлыг барилга байгууламжийн засварын ангилалд;
- "Гандан-Тэгчилэн" хийдийн түүх соёл, шашны дурсгалт зүйлийг сэргээн тохижуулах / УБ хот БГД / -ийн 1,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй сэргээн тохижуулах ажлыг барилга, байгууламжийн ангиллаар батлуулсан байна.

Баталгаажсан зураг, төсөвгүй барилга, байгууламжийн төсөвт өртгийг Төсвийн тухай хуульд ерөнхий тоогоор батлуулсан нь зураг, төсвийг боловсруулж, магадлалаар баталгаажуулахад төсөвт өртөг нэмэгдэх үндсэн шалтгаан болж байна. Тухайлбал зарим барилга, байгууламжийн нэмэлт ажлын зураг, төсвийг хууль батлагдахаас өмнө магадлал хийлгэж баталгаажуулаагүйгээс төсөвт өртөг нь 1,748.1 сая төгрөгөөр нэмэгдэж батлагдсан байна. Үүнд:

- Цэцэрлэгийн барилгыг буулгаж, шинээр барих, 240 ор / УБ хот ХУД, 28 дугаар цэцэрлэг/ төслийн 2,200.0 сая төгрөгийн төсөвт өртөг 728.1 сая төгрөгөөр;
- Цэцэрлэгийн барилга, 250 ор / УБ хот СХД, 31 дүгээр хороо/ төслийн 2,000.0 сая төгрөгийн төсөвт өртөг 500.0 сая төгрөгөөр;
- Цэцэрлэгийн барилга, 150 ор / УБ хот СХД, 10 дугаар хороо/ төслийн 1,500.0 сая төгрөгийн төсөвт өртөг 250.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Хөрөнгө оруулалтын жагсаалтад зураг төсөвгүй батлагдсан ажлаас 8,121.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 16 ТАХ төсвийн тодотголоор хасагдсан байна. Хавсралт 1.

Дүгнэлт: Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ -г төлөвлөхдөө Төсвийн тухай хуульд заасан төсөвлөлтийн шаардлагыг хангуулаагүйгээс ТАХ-ний төсөвт өртөг нь нэмэгдэх, ТАХ хэрэгжихгүй болох зэрэг сөрөг үр дагавар үүсэж байна.

3.9. Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын ба хязгаарлалтын бүсэд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 3.9.11. орон сууц, үйлдвэр, үйлчилгээний зориулалттай барилга байгууламж барьж ашиглах; 3.9.12. газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгох

⁶ 22.2. Төсвийг дор дурдсаны дагуу ангилна:

⁷ 22.2.3. эдийн засгийн ангиллаар;

⁸ 2.1.1. "Барилга байгууламж" гэж "Барилгын тухай хуульд" хуулийн 4.1.1-т зааснаар барилгын норм дүрмийн дагуу боловсруулж, магадлал хийгдсэн зураг төслөөр тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн барьсан орон сууц иргэн, үйлдвэр эрчим хүч, харилцаа холбоо, зам гүүр ус нефтийн барилга, ус суваг, далан хаалт зэрэг байгууламж түүний инженерийн шугам сүлжээг;



А.3.3. Төсөл, арга хэмжээг хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож, санхүүжилтийг батлуулсан уу?

Төсвийн тухай хуулийн 29.3.5⁹-д шинээр эхлэх ТАХ-ний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь ТАХ-г хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар заасан.

НЗД-д эрх шилжүүлсэн улсын төсвийн хөрөнгө ор уулалтаар хэрэгжих 41,777.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 37 ТАХ-ний тухайн онд санхүүжих дүнг 13,528.3 сая төгрөг буюу 64.8%-иар дутуу баталжээ. Хавсралт 2.

Хүснэгт 4.Тухайн онд санхүүжих дүнг дутуу баталсан ТАХ /ТЕЗ-аар/

№	ТЕЗ нэр	ТАХ тоо	Батлагдсан		Санхүүжих дүнгийн зөрүү	
			Төсөвт өртөг	Тухайн онд санхүүжих дүн	ТАХ-г хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан байх дүн	Дутуу баталсан дүн
1	ЗГХЭГД	2	3,600.0	200.0	1,800.0	(1,600.0)
2	БОАЖС	1	2,900.0	500.0	1,450.0	(950.0)
3	БХБС	7	9,490.0	1,170.0	4,745.0	(3,575.0)
4	БШУС	6	2,145.0	486.0	1,072.5	(586.5)
5	СоёлС	2	2,000.0	450.0	1,000.0	(550.0)
6	ЗТХС	17	21,192.5	4,394.5	10,596.3	(6,201.8)
7	ЭМС	2	450.0	160.0	225.0	(65.0)
Нийт		37	41,777.5	7,360.5	20,888.8	(13,528.3)

Хүснэгтээс харахад тухайн онд санхүүжүүлэх шаардлагатай дүнгээс ЗГХЭГ-ын даргын багцад 1,600.0 сая, БХБС-ын багцад 3,575.0 сая, ЗТХС-ын багцад 6,201.8 сая төгрөгийн дүнг дутуу баталсан байна.

Энэ нь барилга байгууламж, зам тээвэр, дэд бүтцийн төрлийн ажлууд төлөвлөсөн онд бүрэн хэрэгжиж дуусахгүй байх, он дамжин хэрэгжих, удаашрах, олон жилээр хэрэгжихгүй орхигдох зэргээр ажлын үр дүн бүтээмжид нөлөөлөх сөрөг үр дагавартай байна.

Дүгнэлт: Төсөл, арга хэмжээг хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож, санхүүжилтийг батлуулаагүй зөрчил илэрч байна. Эрх шилжсэн 37 ТАХ-ний тухайн онд олгох санхүүжилтийг 64.8%-иар дутуу тооцсон нь ТАХ төлөвлөсөн хугацаанд хэрэгжих боломжгүй болох, улмаар ажлын гүйцэтгэл, чанар үр дүнд сөргөөр нөлөөлөх нөхцөл ийг үүсгэж байна.

А.3.4. Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл, арга хэмжээг төлөвлөж, батлуулсан уу?

Төсвийн тухай хуулийн 4.1.24¹⁰-д зааснаар төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих ТАХ нь тухайн шатны төсөвт хамаарах этгээдийн өмчлөлд бүртгэгдэх зарлага байдаг. 2020 оны улсын төсвийн хөрөнгө оруула лтаар НЗД-д эрх шилжин ирсэн 253 төсөл арга хэмжээнээс 12,031.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 14 ТАХ нь өмчид бүртгэгдэхгүй хөрөнгө оруулалтын бус шинж чанартай орон сууцны засварын ажлууд байна.

⁹ 29.3.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны Засаг дарга хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт саналыг дараах байдлаар жилийн төсвийн төсөлд тусгана: 29.3.5.шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах.

¹⁰ 4.1.24."хөрөнгө оруулалт" гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;



Хүснэгт 5. Хөрөнгө оруулалтын бус шинж чанартай ТАХ

№	ТАХ-ний нэр	Төрөл	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа	/сая.төг/	
					Төсөвт өртөг	Өртөг
1	Нийтийн зориулалттай орон сууцны барилгын цахилгаан шатны засвар	Их засвар	2020	2020	1,120.0	
2	Нийтийн зориулалттай орон сууцны барилгын дээврийн засвар	Их засвар	2020	2020	1,500.0	
3	Нийтийн зориулалттай орон сууцны барилгын фасадын засвар	Их засвар	2020	2020	1,000.0	
4	Орон сууцны байруудын дулаалга /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 1 дүгээр хороо, 46, 47, 48, 64, 67, 68, 72 дугаар байр, 2 дугаар хороо, ногооны 1-30, 2-30 байр, 3 дугаар хороо, 38, 41, 42, 50, 51-а, 53, 63, 65, 66, 72, 73, 75 дугаар байр/	Их засвар	2020	2020	450.0	
5	Орон сууцны байруудын их засвар /Улаанбаатар, Багахангай дүүрэг, 1 дүгээр хороо/	Их засвар	2019	2020	3,886.1	
6	Нийтийн эзэмшлийн орон сууцны гадна фасадын их засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 7, 8, 10 дугаар хороо/	Их засвар	2020	2021	400.0	
7	Нийтийн эзэмшлийн орон сууцны дээврийн засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 10 дугаар хороо, 2А хэсгийн 5, 10, 17 дугаар байр/	Их засвар	2020	2020	97.0	
8	Нийтийн эзэмшлийн орон сууцны орцын их засвар /Улаанбаатар, Багануур дүүрэг, 1 дүгээр хороо/	Их засвар	2020	2021	150.0	
9	Нийтийн эзэмшлийн орон сууцны орцын их засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 7, 8, 9, 10 дугаар хороо/	Их засвар	2020	2021	900.0	
10	Орон сууцны байруудын дээврийн их засвар /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 8, 10, 12, 13, 14, 22 дугаар хороо/	Их засвар	2020	2020	300.0	
11	Орон сууцны гадна фасадын засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 7, 8, 10 дугаар хороо/	Их засвар	2020	2021	1,000.0	
12	Орон сууцны дээвэр, гадна фасадын засвар /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 6 дугаар хороо, 58а, 58б, 58в, 58г байр/	Их засвар	2020	2021	1,000.0	
13	Орон сууцны фасад, дээврийн их засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 3 дугаар хороо, "Ганжигүүр" СӨХ, 43, 45 дугаар байр/	Их засвар	2020	2020	132.0	
14	Орон сууцны фасадын их засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 3 дугаар хороо, "Голланд байшин" СӨХ, 41 дүгээр байр/	Их засвар	2020	2020	96.1	
Нийт					12,031.2	

Төсвийн төсөл боловсруулах ад мөрдөгдөх эрх зүйн баримт бичигт тусгаснаар тэргүүлэх ач холбогдолтой, зайлшгүй хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлагатай, тооцоо судалгаатай, уялдаа бүхий томоохон бүтээн байгуулалтын ажлуудыг улсын төсөвт тусган хэрэгжүүлэхэд чиглэгдэж байна.

Гэтэл 2020 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад 88.0 сая төгрөгөөс бага өртөг бүхий 71 ТАХ -г /засвар үйлчилгээ, тоног төхөөрөмж зэрэг/ баталсан, тусгах ажлын төсөвт өртгийн дүн, хэмжээг зааглаагүй нь улсын хэмжээний томоохон ТАХ-ний тухайн онд санхүүжүүлэх дүнг бууруулахад зарим талаар нөлөөлж байна. Хавсралт 3.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад тусгах шаардлагагүй нийслэл, дүүргийн, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх боломжтой төсөвт өртөг нь 30.0 сая төгрөгөөс бага дүн бүхий зарим ажлыг тусгасан байна.

Хүснэгт 6. Нийслэл, дүүргийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх боломжтой ТАХ

Д.д	ТАХ-ний нэр	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа	Төсөвт өртөг	/сая.төг/	
					2020 онд санхүүжих дүн	Өртөг
1	7 дугаар байрны дээвэр /БХД, 2 дугаар хороо/	2020	2020	28.0	28.0	
2	Орон сууцны гадна талбайн камержуулалт /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 8 дугаар хороо, 48в байр/	2020	2020	10.0	10.0	
3	Сургуулийн талбай тэгшлэлт /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 12 дугаар хороо, 138, 220 дугаар сургууль/	2020	2020	25.0	25.0	
4	Цэцэрлэгийн барилгын цахилгааны засвар /Улаанбаатар, Налайх дүүрэг, 152 дугаар цэцэрлэг/	2020	2020	20.0	20.0	



5	Сургуулийн спорт заалны засвар /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 38 дугаар сургууль/	2020	2020	25.0	25.0
6	"Эрдмийн ундраа цогцолбор" сургуулийн хичээлийн 2 байрны 1, 2 дугаар давхрын ариун цэврийн өрөөний засвар /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2020	2020	21.0	21.0
7	Цэцэрлэгийн барилгын засвар /Улаанбаатар, Багануур дүүрэг, 194 дүгээр цэцэрлэг/	2020	2020	15.0	15.0
8	Яаралтай түргэн тусламжийн автомашин /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 14 дүгээр хороо/	2020	2020	20.0	20.0
Нийт дүн				164.0	164.0

Дүгнэлт: НЗД-д эрх шилжин ирсэн 253 ТАХ-ээс 14 буюу 5.5% нь хөрөнгө оруулалтын бус шинж чанартай ажил байна.



БҮЛЭГ 2. Б.УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮНТЭЙ БАЙНА УУ?

Б.1.Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулагдсан уу?

МУ-ын төсвийн хөрөнгөөр 2020 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад тусгагдсан шинээр хэрэгжих 139,399.2 сая төгрөгийн төсөвтэй 197 ТАХ -ний ХАА-г зохион байгуулах эрхийг холбогдох ТЕЗ-даас нийслэл, дүүргийн ЗД-д шилжүүлжээ. Үүнд:

- ТЕЗ-даас /БОАЖС, БСШУСС, БХБС, ЗТХС, ХХААХҮС, ЭМС, ЗГХЭГД зэрэг 7/ 137,299.2 сая төгрөгийн төсөвтэй 196 ТАХ -г НЗД-д;
- Төрийн Худалдан авах ажиллагааны газрын даргын 2020 оны А-1/119 дугаар албан бичгээр 2,000.0 сая төгрөгийн төсөвтэй 1 ТАХ -г СХД-ийн ЗД-д шилжүүлжээ.

НЗД-ын 53 удаагийн захирамжаар эрхийг харьяа 14 байгууллагад шилжүүлж, ХАА-г зохих хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулахыг даалгажээ.

Мөн 2019 онд зохион байгуулж дуусаагүй байсан 21,779.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 ТАХ -ний ХАА-г 2020 онд зохион байгуулсан байна.

2019 оноос шилжсэн 9, 2020 оны 197, нийт 206 ТАХ-ээс 127,125.5 сая төгрөгийн төсөвтэй 148 ТАХ буюу 71.8% -ийн ХАА-г 2020 онд багтаан зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулжээ. Үүний 112,927.3 сая төгрөгийн төсөвтэй 141 ТАХ шинэ, 14,198.2 сая төгрөгийн төсөвтэй 7 ТАХ нь 2019 оноос шилжсэн байна.

Хүснэгт 7. ТАХ-ний худалдан авалт

№	ТЕЗ	ХАА зохион байгуулах ТАХ			ХАА зохион байгуулсан ТАХ				/сая.төг/
		ТАХ тоо	Төсөвт өртөг	Захирамж тоо	ТАХ тоо	Төсөвт өртөг	Шалгарсан өртөг	Хэмнэлт	
1	БНД-ийн ХААА	7	1,462.6	5	5	1,367.6	1349.9	17.7	
2	БГД-ийн ХААА	10	6,011.0	4	10	6,011.0	5944.9	66.1	
3	БЗД-ийн ХААА	3	900.0	3	3	900.0	882.4	17.6	
4	НАЗХГ	3	6,440.0	1	2	5,440.0	4,922.0	518.0	
5	НОСДБГ	1	5,000.0	1	1	5,000.0	4,966.2	33.8	
6	НХБХГ	5	200.0	1	5	200.0	186.4	13.6	
7	НХОГ	5	8,786.1	4	5	8,786.1	5,165.6	0.1	
8	НХААГ	89	64,658.0	15	48	43,450.5	41,295.0	2,155.5	
9	СХД-ийн ХААА	15	15,198.2	5	13	12,633.2	12,126.7	506.5	
10	УБ хотын ЗАА	48	14,248.1	6	47	14,174.2	13,356.5	817.7	
11	УБХК ХХК	1	22,000.0	1	1	22,000.00	21,393.8	606.2	
12	УСУГ	3	2,515.0	2	2	515.0	404.0	111.0	
13	ХУД-ийн ХААА	8	6,784.9	2	3	3,607.9	3,458.4	149.5	
14	ЧД-ийн ХААА	8	6,975.0	3	3	3,040.0	2,962.3	77.7	
	Нийт	206	161,178.9	53	148	127,125.5	118,414.1	5,091.0	


Харин 2020 онд 34,053.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 58 ТАХ дараах байдлаар хэрэгжээгүй байна. Үүнд:

- 18,682.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 29 ТАХ-ний ХАА-г зохион байгуулсан ч тендерт оролцогч ирээгүй, батлагдсан төсөв нь хүрэлцээгүй, газаргүй, газрын маргаантай, зураг төсөвгүй, архитектор төлөвлөлтийн болон ажлын даалгаваргүй, зэргээр төлөвлөлтийн үе шатны тооцоо судалгааг хангалтгүй хийгдсэнээс төсвийн тодотголоор хөрөнгө нь хасагдаж хэрэгжих боломжгүй болсон;
- 2,664.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 ТАХ -ий худалдан авах үнэлгээний хороо байгуулагдсан ч зураг төсөвгүй болон бусад шалтгаанаар төсвийн тодотголоор хөрөнгө нь хасагдаж ХАА зохион байгуулагдаагүй;
- 11,988.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 18 ТАХ-ний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан ч төсвийн тодотголоор хөрөнгө нь хасагдаж тухайн онд хэрэгжээгүй;
- 718.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 ТАХ-ний ТББ боловсруулах, үнэлгээ хийх зэргээр тухайн онд бүрэн дуусаагүй, 2020 -2021 он дамжин зохион байгуулсан байна.



Гүйцэтгэгч нь сонгон шалгарсан 148 ТАХ-г төрлөөр авч үзвэл машин, техник, тавилга тоног төхөөрөмж 29.0%, барилга, байгууламж 22%, зам, замын байгууламж 16%, дэд бүтэц 14%-тай байгаа бөгөөд дээрх ТАХ-үүд нь дийлэнх буюу 81.0%-ийг нь эзэлж байна.

ТАХ-нд эзлэх хувийн жин, төрлөөр



Б.1.1. Төсөл, арга хэмжээг хэрэгжих боломжтой хугацаанд эрх шилжүүлсэн үү?

УИХ-аас МУ-ын 2020 оны Төсвийн тухай хуулийг 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр баталж, 2020 оны 8 дугаар сарын 28 -ны өдөр тодотгосон байна.

ТБОНӨХБАҮХАТХ -ийн 46 дугаар зүйлийн 46.1¹¹-т барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг тухайн жилийн төсөв батлагдсан даруйд эхлүүлэх, Сангийн сайдын 2017 оны 363 тоот тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам” -ын 2.13¹²-т эрх шилжүүлэх хугацааг төсөв батлагдсанаас хойш 60 хоногийн дотор, тодотгол орсон бол түүнээс хойш 30 хоногийн дотор тус тус холбогдох албан тушаалтанд шилжүүлсэн байхаар заажээ.

Гэтэл ТЕЗ-даас 2020 онд хэрэгжиж эхлэх нийт 9 ТАХ-г дээрх хугацаанд багтаан эрх шилжүүлсэн, харин 152,768.9 сая төгрөгийн төсөвтэй 197 ТАХ -ний эрхийг НЗД-д эрх шилжүүлэхдээ 5-212 хоногийн хугацаагаар хоцроож буюу 2020.01.22-2021.08.21-ний хооронд хүргэсэн байна.

Хүснэгт 8. ТЕЗ-аас ТАХ-ний эрхийг шилжүүлэхэд зарцуулсан хугацаа

№	ТЕЗ-ын нэр	ТАХ-ний		Хоцроосон хугацаа /хоног-р/
		Тоо	Төсөвт өртөг /сая.төг/	
1	БХБС	90	48,361.6	5-67
2	БСШУСС	64	35,098.1	5-212
3	ЗТХС	31	59,022.2	15-57
4	ЭМС	8	3,740.0	22
5	БОАЖС	3	5,947.0	16
6	ХХААХҮС	1	600.0	21
	Нийт	197	152,768.9	

¹¹ 46.1.Захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авах талаар дараах эрх, үүрэгтэй байна: 46.1.8 .барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг тухайн жилийн төсөв батлагдсан даруйд эхлүүлэх;

¹² 2.13.Захиалагч хуулийн 46.3-т заасны дагуу эрх шилжүүлэх тохиолдолд төсөв батлагдсанаас хойш 60 хоногийн дотор,хэрэв тодотгол орсон бол түүнээс хойш 30 хоногийн дотор тус тус холбогдох албан тушаалтанд шилжүүлсэн байх.



НЗД нь эрх шилжсэн 205 ТАХ-ний ХАА зохион байгуулах эрхийг холбогдох харьяа газруудад 9-84 хоногийн дараа шилжүүлжээ.

Хүснэгт 9. НЗД-аас ТАХ-ний эрхийг шилжүүлэхэд зарцуулсан хугацаа

№	Эрх шилжсэн газар	ТАХ-ний		Хоцроосон хугацаа /хоног-р/
		Тоо	Төсөвт өртөг /сая.төг/	
1	БНД-ийн ХААА	7	1,462.6	11-38
2	БГД-ийн ХААА	10	6,011.0	23-40
3	БЗД-ийн ХААА	3	900.0	22-33
4	НАЗХГ	3	6,440.0	30
5	НОСДБГ	1	5,000.0	60
6	НХБХГ	5	200.0	56
7	НХОГ	5	8,776.1	30-44
8	НХААГ	89	64,558.0	9-74
9	СХД-ийн ХААА	14	13,198.2	9-40
10	УБ хотын ЗАА	48	14,258.1	9-84
11	УБХК ХХК	1	22,000.0	52
12	УСУГ	3	2,515.0	25-61
13	ХУД-ийн ХААА	8	6,784.9	33-38
14	ЧД-ийн ХААА	8	6,975.0	22-60
	Нийт	205	159,078.9	

ТЕЗ-даас эрхийг дээрх байдлаар хугацаа хоцроож шилжүүлж байгаа нь тухайн ТАХ төлөвлөгдсөн хугацаанд дуусахгүй байх, тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай ТАХ хэрэгжиж эхлэхгүй байх зэрэг сөрөг үр дагаврыг бий болгож байна.

Дүгнэлт: ТЕЗ-даас хэрэгжих боломжтой хугацаанд эрх шилжүүлээгүй улмаас 205 ТАХ-ний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.

Б.1.2. ТАХ-г тайлант онд бүрэн хэрэгжих боломжийг хангахуйцаар ХАА-г зохион байгуулсан уу?

НЗД-ын 53 удаагийн захирамжаар ТАХ-ний ХАА-г зохион байгуулж, гүйцэтгэгч сонгон шалгаруулах эрхийг харьяа 8 байгууллага, 6 дүүргийн ЗД-д шилжүүлжээ.

Эрх шилжүүлсний дараа ХАА-г зохион байгуулах үнэлгээний хороо байгуулахад дараах байдлаар хугацаа зарцуулсан байна. Үүнд:

- 103,709.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 113 ТАХ -ний 0-5 хоногт багтаан байгуулсан;
- 46,978,0 сая төгрөгийн өртөгтэй 64 ТАХ -нд 6-36 хүртэл хоног;
- 10,391.0 сая төгрөгийн өртөгтэй 29 ТАХ -нд үнэлгээний хороо байгуулахад 40-өөс 138 хүртэл хоногийн хугацаа зарцуулжээ.

Үнэлгээний хороод байгуулагдсан ч газрын зөвшөөрөл, зураг төсөв, зургийн даалгавар, ажлын даалгавар, техникийн тодорхойлолт болон холбогдох баримт материал нь дутуу, боловсруулагдаагүй байсан зэрэг шалтгаанаар нийт 62 ТАХ, үүнээс 28 ТАХ-ний ХАА-г зохион байгуулж эхлэхэд 30-60 хүртэл хоног, 34 ТАХ 63-273 хоногийн хугацаа алдсан байна. Хавсралт 4. Дээрх 62 ТАХ-ээс 10 буюу 16.1%-ийн сонгон шалгаруулах ажиллагаа 2020 оны 08 дугаар сараас хойш зарлагдсан байна.

Тендерт оролцогчдын ерөнхий нөхцөл, санхүүгийн чадавх, техникийн болон туршлагын шаардлага хангаагүй, тендер ирүүлээгүй зураг, төсөв зөрүүтэй, ТЕЗ -аас цахим системээр эрх шилжүүлээгүй зэрэг шалтгаанаар 53 ТАХ-ний ХАА 2-3 удаа зохион байгуулагдсанаас хугацаа хойшлогдсон байна.

Дээрх байдал нь 8 ТАХ-ний гүйцэтгэгчтэй байгуулах гэрээ 10 сараас хойш байгуулагдан тухайн жилд дуусах боломжгүй болсон, 24 ТАХ-ний хөрөнгө нь төсвийн тодотголоор хасагдахад тодорхой хэмжээнд нөлөөлсөн байна.



Хүснэгт 10. 2-3 удаа зохион байгуулсан ТАХ /тоогоор/

Үзүүлэлт	2 удаа	3 удаа
Шаардлагад нийцсэн тендер ирүүлээгүй	13	
Тендер ирүүлээгүй /оролцогчгүй/	27	9
Бусад	4	
Нийт	44	9

Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, газрын зөвшөөрөл, техникийн нөхцөлгүй ТАХ -г улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад баталж Төсвийн тухай хуулийн 29.4¹³-д заасны зөрчсөнөөс шалтгаалж 40,989.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 42 ТАХ-ний ХАА түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэйгөөр зохион байгуулагджээ. Хавсралт 5.

Хугацаа алдсанаас 2020 онд зохион байгуулахаар батлагдсан ТАХ-ний 119 буюу 57.7%-ийн ХАА нь 5 дугаар сарын 01-нээс хойш зарлагдсан, эдгээрээс 14 ТАХ буюу 11.7% нь бүтээн байгуулалтын ажил зогсох хугацаа буюу 9 дүгээр сарын 01 - нээс хойш гэрээ нь байгуулагдсан байна.

Дээрх байдлууд нь батлагдсан ТАХ хэрэгжихгүй болох, тухайн онд бүрэн хэрэгжиж дуусах боломжгүй болох эрсдэлийг үүсгэж байна.

Дүгнэлт: ТАХ нь батлагдсан зураг төсөвгүй, газрын зөвшөөрөлгүй, техникийн нөхцөлгүй, үнэлгээний хороог оройтож байгуулсан зэрэг нь ХАА-г төлөвлөсөн хугацаандаа зохион байгуулах боломжгүй байдалд хүргэж байна.

Б.1.3. Тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу боловсруулсан уу?

Үнэлгээний хороод нь ТББ боловсруулахдаа Сангийн сайдын баталсан жишиг баримт бичгийн тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа, агуулга, гэрээний ерөнхий нөхцөл хэсгүүдэд өөрчлөлт оруулдаггүй байна. Харин өөрийн эрх хэмжээний хүрээнд ТШӨХ, тендерийн баталгаа, гэрээний тусгай нөхцөл, техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, үе шатны ажлын хуваарь, урилга зэрэг хэсгүүдэд холбогдох өөрчлөлтийг хийдэг байна. Тендерийн баталгаа, гэрээний тусгай нөхцөл, техникийн тодорхойлолт, үе шатны ажлын хуваарь, урилга зэргийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд боловсруулсан байна.

Аудитаар 2020 онд ХАА зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан 148 ТАХ-ээс 114 ТАХ буюу 77.0%-ийг түүвэрт хамруулан тулган баталгаажуулалт хийхэд зарим үнэлгээний хороод тендерийн баримт бичгийг боловсруулахдаа холбогдох хууль, журмыг зөрчсөн байна. Үүнд:

- СХД-ийн 3Д-ын А/144, А/183 захирамжаар байгуулагдсан үнэлгээний хороод тендерийн бичиг баримт, техникийн тодорхойлолт боловсруулахдаа ТБОНӨХБАУХАТХ-ийн 11.1.1¹⁴ 12.2¹⁵-д заасныг зөрчсөнөөс шалтгаалж 750.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ТАХ -ний хүрээнд /43 барааны нэршлийг тодорхойгүй, үзүүлэлтийг нь дутуу тусгасан./ нийлүүлэгдсэн хөрөнгө оруулалтаас 95.4 сая төгрөг нь үр ашиггүй хөрөнгө оруулалт болсон байна. Үүнд:
 - Сургуулиудад олон улсын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 18, 19, 23, 29 дүгээр хороо/.

¹³ 29.4.хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

¹⁴ 11.1.Захиалагч техникийн тодорхойлолтыг бэлтгэхдээ дараах шаардлагыг хангасан байна: 11.1.1.тухайн бараа, ажил, үйлчилгээг гадаад шинж чанарын үзүүлэлтээр бус, зориулалт, эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээ, ашиглалт, чанарын түвшин, техникийн болон тухайн бараа, ажил, үйлчилгээ нь байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, ногоон орчныг бүрдү үлэхэд чиглэсэн шалгуур үзүүлэлтээр тодорхойлох;

¹⁵ 12.2.Захиалагч тухайн тендер шалгаруулалтад тавигдах чадавхийн шалгуур үзүүлэлт, шаардлагыг энэ хуулийн 14 -16 дугаар зүйлд нийцүүлэн тогтоож, тендерийн баримт бичигт тусгана.



Техникийн тодорхойлолтод суурин компьютерын иж бүрдлийг “суурин компьютер” нэрээр оруулж процессорын “intel Core™ i5-9400 4.6GHz /4GB DDR4/ 1TB HDD/DVD-RW/Wifi” үзүүлэлтийг тусгасан. Гүйцэтгэгч техникийн тодорхойлолтод тусгагдсан үзүүлэлтийн дагуу нийт 71.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 42 ширхэг компьютерын процессор нийлүүлжээ.

- Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 18, 19, 23, 27, 39 дүгээр хороо/. Үнэлгээний хороо ТБОНӨХБАҮХАТХ -ийн 47.2.1¹⁶, 47.3.1¹⁷-д заасныг зөрчсөнөөс шалтгаалан ашиглагч байгууллагын ирүүлсэн “Macbook pro/16инч/8-core/64GB/8T” үзүүлэлтийн дагуу техникийн тодорхойлолтыг хяналгүйгээр батлуулсан. Гэтэл гүйцэтгэгчээр шалгарсан “Санни-Лайф” ХХК-нь дээрх үзүүлэлт бүхий 24.0 сая төгрөгийн компьютерыг гэрээний хугацаанд нийлүүлэх боломжгүй гэсэн шалтгаанаар зөөврийн компьютерын үзүүлэлтийг бууруулан 12.0 сая төгрөгөөр, үнийн зөрүүнд шалгалтын хуудас уншигч машин, урсдаг электрон самбарын техникийн үзүүлэлтийг нэмэгдүүлэн нийлүүлжээ.

Иймд үнэлгээний хороод тендерийн баримт бичиг боловсруулахдаа хууль журмыг мөрдөж, хөрөнгө оруулалтын үр өгөөж ийг сайжруулахад анхаарах шаардлагатай байна.

Дүгнэлт: Үнэлгээний хороо тендерийн баримт бичгийг боловсруулахдаа ашиглагч байгууллагын саналд туссан барааны нэр, үзүүлэлтийг хяна агүй, хууль журмыг зөрчсөн нь хөрөнгө оруулалтын үр ашиг, үр дүнд сөрөг нөлөөтэй байна .

Б.1.4. Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан уу?

НЗД-аас ХАА-г зохион байгуулах эрх шилжүүлсэн газрын дарга нарын 64 удаагийн тушаалаар ХАА-г зохион байгуулан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороодыг байгуулж, 148 ТАХ-ний гүйцэтгэгчийг шалгаруулжээ. Мөн тендерийн баримтыг хүлээн авах, үнэлгээ хийх шатанд байгаа 4 ТАХ, хэрэгжээгүй 54 ТАХ байна.

Гүйцэтгэгч сонгон шалгарсан ТАХ-нээс 148 буюу 93.9%-ийг нь нээлттэй тендер сонгон шалгаруулалтын журмаар, 6.0%-ийг нь бусад аргаар зохион байгуулжээ.

Хүснэгт 11. ТАХ-ний худалдан авалтын судалгаа

№	ХАА зохион байгуулсан газар	Нээлттэй тендер шалгаруулалт		Харьцуулалтын арга		Шууд гэрээ байгуулах арга		Нийт	
		Тоо	Шалгарсан өртөг	Тоо	Шалгарсан өртөг	Тоо	Шалгарсан өртөг	Тоо	Шалгарсан өртөг
1	БНД-ийн ХААА	5	1,349.9	-	-	-	-	5	1,349.9
2	БГД-ийн ХААА	10	5,944.9	-	-	-	-	10	5,944.9
3	БЗД-ийн ХААА	3	882.4	-	-	-	-	3	882.4
4	НАЗХГ	2	4,922.0	-	-	-	-	2	4,922.0
5	НОСДБГ	1	4,966.2	-	-	-	-	1	4,966.2
6	НХБХГ	5	186.4	-	-	-	-	5	186.4
7	НХОГ	1	398.9	-	-	4	4,766.8	5	5,165.7
8	НХААГ	48	41,295.0	-	-	-	-	48	41,295.0
9	СХД-ийн ХААА	13	12,126.7	-	-	-	-	13	12,126.7
10	УБ хотын ЗАА	44	12,520.3	2	136.7	1	699.3	47	13,356.3
11	УБХК ХХК	1	21,393.8	-	-	-	-	1	21,393.8
12	УСУГ	1	339.0	1	65.0	-	-	2	404.0
13	ХУД-ийн ХААА	3	3,458.4	-	-	-	-	3	3,458.4
14	ЧД-ийн ХААА	2	2,923.1	1	39.2	-	-	3	2,962.3
	Нийт	139	112,707.0	4	240.9	5	5,466.1	148	118,414.0

¹⁶ 47.2.1.техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн урилга, тендерийн баримт бичгийг боловсруулах, тендер хүлээн авах, тендер нээх ажиллагааг холбогдох зааврын дагуу гүйцэтгэх;

¹⁷ 47.3.1.худалдан авах ажиллагааны чиглэлээр, эсхүл тухайн бараа, ажил, үйлчилгээнд холбогдох салбарт мэргэшсэн байх;



ХАА-ны ил тод байдлыг хангах хүрээнд ТБОНӨХБАҮХАТХ -ийн 47.4¹⁸-д заасны дагуу нийслэл дүүргийн ЗДТГ-ын салбарын мэргэжилтнүүд, захиалагч байгууллагын төлөөлөл, ИТХ -аас томилсон зөвшөөрөл бүхий давхардсан тоогоор 191 иргэнийг үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд оролцуулж ажилласан байна. Мөн 21.2¹⁹-т заасан тендер шалгаруулалтын тухай дэлгэрэнгүй мэдээллийг ил тод, нээлттэй байлгах хүрээнд www.tender.gov.mn цахим хуудас болон өдөр тутмын сонинд давхардсан тоогоор 182 удаагийн тендерийн урилгыг нийтэлжээ.

Аудитаар 2020 онд ХАА зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан 148 ТАХ-нээс 114 ТАХ буюу 77.0%-ийг түүвэрт хамруулан тулган баталгаажуулалт хийхэд зарим зөрчил илэрч байна.

ХАА-г зохион байгуулахдаа үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой заавар журмуудыг мөрдөөгүй, ТББ-д тусгасан санхүү, боловсон хүчин, техникийн чадавх, тоног төхөөрөмж, тусгай зөвшөөрөл, туршлагын шалгуур үзүүлэлтүүдийг харгалзаагүй нь ТБОНӨХБАҮХАТХ -ийн 12.3²⁰ дахь заалтыг зөрчсөн байна. Үүнд,

Тусгай зөвшөөрлийн шаардлага хангаагүй:

Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт (ТШӨХ) -д заасан тусгай зөвшөөрлийн шаардлага хангаагүй 1,300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ сонгон шалгаруулсан байна. Үүнд:

СХД-ийн ХААА-аас зохион байгуулсан 1 ТАХ.

- Сургуулийн дотуур байрын барилга, 70 ор /УБ хот СХД, 21 дүгээр хороо/, Төсөвт өртөг 1,300.0 сая төгрөг. Гүйцэтгэгч “Морин сувд ХХК”. Зураг төсөв боловсруулах байгууллагын тусгай зөвшөөрлийн хавсралт ыг ирүүлээгүй.

Санхүү, боловсон хүчин, техникийн чадавх, тоног төхөөрөмж, туршлагын шалгуур хангаагүй:

Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт (ТШӨХ) -д заасан Санхүү, боловсон хүчин, техникийн чадавх, тоног төхөөрөмж, туршлагын шалгуур хангаагүй 5,600.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ТАХ сонгон шалгаруулсан байна. Үүнд:

СХД-ийн ХААА-аас зохион байгуулсан 2,700.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ТАХ.

- “Толгойтын замаас Хүнсчдийн гудамжтай холбох хатуу хучилттай авто зам, 0.8 км” / УБ хот СХД, 4 дүгээр хороо/, Төсөвт өртөг 1,200.0 сая төгрөг. Гүйцэтгэгч “Тэмүүн холдинг ХХК”. Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй, тухайн ажлыг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай геодезийн инженергүй;
- “Тоосгоны 20 дугаар гудамжнаас Хангай зах хүртэлх хатуу хучилттай авто зам, 1 км” /УБ хот СХД, 6 дугаар хороо/, Төсөвт өртөг 1,500.0 сая төгрөг. Гүйцэтгэгч “Баян өлзийт зам ХХК” нь тухайн ажлыг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай геодезийн инженергүй;

НХААГ-аас зохион байгуулсан 2,900.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ

- Соёл, спорт, аялал жуулчлалын цогцолборын хувцас солих байр, тусламж үйлчилгээ, нийтийн соёл үйлчилгээний барилга байгууламж, өвлийн спортын талбай / УБ хот ЧД, 19 дүгээр хороо дээд Салхит/, Төсөвт өртөг 2,900.0 сая төгрөг. Гүйцэтгэгч “Саран инж девелопмент ХХК”. барилгын инженер ажилласан жилийн туршлага дутуу;

¹⁸ 47.4.Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна.

¹⁹ 21.2.Захиалагч тендер шалгаруулалтын тухай дэлгэрэнгүй мэдээллийг ил тод, нээлттэй зарлах бөгөөд сонирхсон этгээдэд саадгүй олгоно.

²⁰ 12.3.Энэ хуулийн 12.2 дахь хэсэгт заасны дагуу захиалагчийн тогтоосон чадварын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаагүй тендерээс татгалзаж, энэ тухай тендер ирүүлсэн этгээдэд бичгээр мэдэгдэнэ.



Тендерийг хянан үзэхдээ ТБОНӨХБАҮХАТХ -ийн 27.1²¹, 27.1.3²²-т заасныг зөрчсөнөөс шалтгаалан ТББ-т заасан бусад шаардлага /газрын асуудал/, магадлалын дүгнэлт /13,000.0 сая төгрөгөөр баталгаажсаныг/ зэргийг хянахгүйгээр сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, магадлалын дүгнэлтээс 2,000.0 сая төгрөгөөр илүү төсөвт өртөг өндөртэй, газрын асуудал шийдэгдээгүй тендер сонгон шалгаруулжээ. Үүнд:

НХААГ-аас зохион байгуулсан 15,000.0 сая төгрөгийн төсөвт өртөг гэтэй 1 ТАХ.

- Сургууль, цэцэрлэгийн цогцолбор худалдан авах /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 29 дүгээр хороо/-ийн төсөвт өртөг 15,000.0 сая төгрөг. Гүйцэтгэгч “Сүмт -Өргөө” ХХК нь тендерийн баримт бичгийн 12.1 (ё) 1-16-д заасан нэмэлт материал ирүүлэхээс 6, 7, 10, 11 дэх хэсгийг ирүүлээгүй. Үүнд:

- 6-д Газар болон барилга байгууламж нь ямар нэгэн барьцаа, эд хөрөнгө болон газрын маргаангүй тухайн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн болон холбогдох газрын тодорхойлолт;
- 7-д Газрын төлбөр, байрны ашиглалтын зардлын өр төлбөргүй талаар холбогдох байгууллагуудтай тооцоо нийлсэн акт;
- 10-д Тухайн газар болон барилга байгууламжийг худалдахыг зөвшөөрсөн мэдүүлгийг компанийн дүрэм, улсын бүртгэлийн гэрчилгээнд заасан компанийн хувьцаа эзэмшигч тус бүрээр;
- Тендерийг хянан үзэхдээ магадлалын дүгнэлтээр баталгаажсан барилгын төсөвт өртгийн дүнг үнэлгээнд харгалзаагүй байна.

Худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүрд тендер шалгаруулалтын архивын нэгж баримт боловсруулсан ч хуулийн 49.2²³-д заасан баримтыг хангалтгүй бүрдүүлсэн байна. Үүнд:

УБ хотын ЗАА-аас зохион байгуулсан 606.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 ТАХ. ТББ-т заасан шалгараагүй мэдэгдэл хүргүүлсэн баримтыг архивын материалд хавсаргаагүй.

- Бурхантын 5.6-р гудамжны гэрэлтүүлэг ХУД 14-р хороо. Төсөвт өртөг 143.4 сая төгрөг;
- Хүрхрээ эко хотхоны гэрэлтүүлэг БЗД 11-р хороо. Төсөвт өртөг 100.0 сая төгрөг, Гэрэлтүүлэг БГД1.2.3.4.5.6-р хороо, Төсөвт өртөг 93.0 сая төгрөг;
- Зүрх-Уулын 6, 7, 8, 9 дугаар гудамж, Баянхайрхан 1, 2 дугаар гудамжны гэрэлтүүлэг /ЧД, 17 дугаар хороо/, Төсөвт өртөг 120.0 сая төгрөг;
- Энгэр шандын гэр хорооллын гэрэлтүүлэг /НД, 1 дүгээр хороо/. Төсөвт өртөг 150.0 сая төгрөг.

НХААГ-аас зохион байгуулсан 15,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ.

- Сургууль, цэцэрлэгийн цогцолбор худалдан авах /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 29 дүгээр хороо/: Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл, шийдвэрийг архивын материалд хавсаргаагүй.

Архивын баримт материалын бүрдэл дутуу байгаа тухайн тендер шалгаруулалт үнэн зөв, ил тод явсан эсэхийг нотлох боломжгүйд хүргэ х эрсэлтэй байна.

²¹ 27.1.Тендер нээсний дараа тендер тус бүр нь дараах шаардлагыг хангасан эсэхийг хянан үзнэ:

²² 27.1.3.тендерийн баримт бичигт заасан бусад нөхцөл, шаардлага

²³ 49.2.Тендерийн хавтаст хэрэг дараахь баримт бичиг, материалаас бүрдэнэ: 49.2.1.худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл, шаардлагатай бол тайлбар; 49.2.2.нээлтэй тендер шалгаруулалтаас өөр арга хэрэглэсэн тохиолдолд тухайн аргыг сонгосон үндэслэл; 49.2.3.худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тухай товч тодорхойлолт, тендерийн баримт бичиг; 49.2.4.захиалагч, тендерт оролцогчтой харилцсан албан бичиг; 49.2.5.тендерт оролцогчдын ирүүлсэн тендер; 49.2.6.тендерийн нээлтийн тэмдэглэл, үнэлгээний дүгнэлт, гэрээ байгуулах эрх олгох тухай зөвлөмж; 49.2.7.тендер шалгаруулалт амжилтгүй болсон, эсхүл бүх тендерээс татгалзсан тохиолдолд түүний шалтгаан, үндэслэл; 49.2.8.гэрээ байгуулах эрх олгох тухай шийдвэр, гэрээ; 49.2.9.тухайн тендер шалгаруулалттай холбоотой бусад баримт бичиг; 49.2.10.гэрээг дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээж авсан баримт бичиг.



ХАА зохион байгуулж дууссан ТАХ-ний 142 буюу 95.9% нь цахим систем ашигласан байна. Харин “НХОГ” ОНӨААТҮГ-аас 25,897.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ТАХ-ний нэмэлт ажлын ХАА-г цаасан буюу уламжлалт хэлбэрээр зохион байгуулсан нь ЗГ-ын 2017 оны 114 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” -ний 4.1.4.1-т заасан тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх заалтыг зөрчжээ. Мөн Сангийн сайдын 2019.02.02 -ны өдрийн 6-1/571 дугаар албан бичгээр ТЕЗ нарт улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ -ний ХАА-г цахимаар зохион байгуулах талаар өгсөн чиглэлийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Хүснэгт 12. “НХОГ” ОНӨААТҮГ-аас ХАА зохион байгуулсан ТАХ

№	ТАХ-ний нэр	Төсөвт өртөг	Шалгарсан гүйцэтгэгчийн нэр	/сая.төг/
1	УБ хотын "Сонгино" 220/110/35 кВ-ын 2х125 МВа дэд станц, 220 кВ-ын 5,8 км цахилгаан дамжуулах агаарын шугамын ажил /Улаанбаатар/	21,597.9	ЭХБУТрест ХХК	
2	Батсүмбэр орох замаас гудамж дундуур арын худаг хүртэлх үерийн далан, 2.5 км /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2,400.0	Хангилцаг ХХК	
3	Цэцэрлэгийн барилга, 200 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 16 дугаар хороо/-1	1,900.0	Бөртэ трейд ХХК	
Нийт		25,897.9		

Иймд илэрсэн зөрчлүүдийг давтан гаргахгүй байх талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд хугацаатай албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Дүгнэлт: Худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулахдаа бүрэн цахимаар зарлаагүй, тендерт ирүүлсэн баримт, материалыг үнэн зөвөөр үнэлээгүй байгаа нь гүйцэтгэгчдийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор бүрэн хангаагүй байна.

Б.1.5. ТЕЗ худалдан авах ажиллагааны тайланг үнэн зөв гаргаж, хугацаанд нь тайлагнасан уу?

Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 3.1²⁴-д ТЕЗ нь тухайн онд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг журамд заасны дагуу нэгтгэж, хагас жилийн тайланг тухайн оны 07.15-ны, бүтэн жилийн тайланг дараа оны 01.15-ны өдрийн дотор төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ гэж заажээ.

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлсэн ТАХ -ний тайлан мэдээг НЗД-ын 2020.07.10-ны өдрийн 02-01/3775, 2021.01.14-ний өдрийн 01/217 дугаар албан бичгүүдээр холбогдох маягтын дагуу гаргаж Сангийн сайдад хугацаанд нь хүргүүлжээ.

Улсын төсвөөс хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ, барилга байгууламжийн жагсаалтад тусгагдсан, ТЕЗ-аас нийслэлд эрх шилжүүлсэн 162,761.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 162 ТАХ-ний ХАА хэрэгжилт 94.9%-тай байна гэж тайлагнажээ.

Аудитаар тулгасан 2019, 2020 онд зохион байгуулсан нийт 161,178.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 206 ТАХ-ээс тайлагнасан төсөвт өртөг нь 1,582.7 сая төгрөгөөр илүү, ТАХ -ний тоо 44-өөр дутуу байна. Энэ нь холбогдох газруудаас ХАА

²⁴ 3.1.Төсвийн ерөнхийлөн захирагч болон төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч этгээд нь тухайн онд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг журамд заасан маягтуудын дагуу нэгтгэж бичгээр болон файлаар төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараах хугацаанд ирүүлнэ. 3.1.1.Х агас жилийн тайланг тухайн оны 7 дугаар сарын 15-ны өдрийн дотор; 3.1.2.Бүтэн жилийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 15 -ны өдрийн дотор;



зохион байгуулахдаа ТАХ-г багцалсан, өмнөх оноос дамжсан ТАХ -ний төсөвт өртгийг тухайн жилд хэрэгжих дүнгээр бус нийт төсөвт өртгөөр тооцож тайлагнасан зэрэгтэй холбоотой байна.

Дүгнэлт: Эрх шилжсэн ТАХ-ний ХАА-ны тайланг хугацаанд нь тайлагнасан ч зарим тоон мэдээг зөрүүтэй илэрхийлсэн байна.

Б.2. Захиалагч гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангуулсан уу?

Улсын төсвийн хөрөнгөөр өмнөх оноос дамжин хийгдсэн 193,424.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй 52, 2020 онд шинээр эхэлсэн 103,079.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй 171, нийт 296,504.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй 223 ТАХ-д УБ хотын ЗАА, НАЗХГ, НБГ, НӨАУГ, НХОГ, НЭМГ, УБ-Лифт зэрэг газруудаас захиалагчийн хяналт хэрэгжүүлжээ.

Хүснэгт 13. ТАХ-ний гэрээний хэрэгжилт

№	Захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн	ТАХ-ний				Үүнээс Дуусаагүй		2020 онд эхлээгүй	
		Тоо		Хэрэгжиж дууссан		Тоо		Тоо	
		Тоо	Гэрээний дүн	Тоо	Гэрээний дүн	Тоо	Гэрээний дүн	Тоо	Гэрээний дүн
1	УБЗАА	8	6,834.2	4	1,754.8	4	5,079.4	-	-
2	НАЗХГ	25	24,726.6	5	1,394.3	14	23,332.3	6	-
3	НБГ	10	2,151.6	9	1,590.8	1	560.8	-	-
4	НМТГ	1	9.9	1	9.9	-	-	-	-
5	ННТҮГ	1	21,393.8	-	-	1	21,393.8	-	-
6	НӨАУГ	3	628.5	3	628.5	-	-	-	-
7	НСУГ	2	50.0	1	50.0	-	-	1	-
8	НХБХГ	1	174.5	-	-	1	174.5	-	-
9	НХОГ	151	235,827.7	39	32,383.4	103	203,444.3	9	-
10	НЭМГ	7	3,661.3	7	3,661.3	-	-	-	-
11	УБ Лифт	14	1,046.3	3	241.2	10	805.2	1	-
	Нийт	223	296,504.6	73	41,888.7	133	254,615.9	17	-

Эдгээрээс 41,888.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй 73 ТАХ буюу 32.7% нь хэрэгжиж дууссан, 254,615.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй 133 ТАХ буюу 57.1 % нь он дамжин хэрэгжиж байна. Харин 17 ТАХ буюу 7.6% нь 2020 онд хэрэгжиж эхлээгүй байна.

2020 оны Төсвийн тухай хуульд тусгагдсаны дагуу өмнөх онуудаас хэрэгжсэн, мөн 2020 оноос эхлэн хэрэгжих 88,849.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй 83 ТАХ-г 2020 онд хэрэгжиж дуусахаар баталжээ. Үүний 17,380.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй 39 ТАХ буюу 47.0% нь тухайн онд хэрэгжиж дууссан байна.



Б.2.1. Гүйцэтгэгч хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг зураг төслийн дагуу гэрээний хугацаанд нь үр дүнтэй гүйцэтгэсэн үү?

Түүвэрт хамруулсан ТАХ-ээс захиалагч болон гүйцэтгэгч нарын хооронд 88,849.6 сая төгрөгийн дүнтэй 83 ТАХ-г 2020 онд хэрэгжиж дуусгах гэрээ байгуулжээ. Эдгээрээс 2020 оны жилийн эцсийн байдлаар 29,795.0 сая төгрөгийн дүнтэй 46 ТАХ буюу 55.4% нь гэрээний хугацаандаа хэрэгжиж дуусжээ. Харин 59,054.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй 37 ТАХ буюу 44.6% нь гэрээний хугацаанд дуусаагүй байна. Үүнд:

Гүйцэтгэгчийн үйл ажиллагаатай холбоотойгоор 23,919.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй 13 ТАХ гэрээний хугацаандаа хэрэгжиж дуусаагүй ажлын явц 60 - 85%-тай байна. Үүнд:

- Гүйцэтгэгч байгууллага гэрээний үүргээ биелүүлээгүйгээс хугацаанд нь хэрэгжүүлж дуусаагүй 9,114.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй 5 ТАХ;
- Усан сан барих газрын зөвшөөрөл олгогдоогүй 3,591.3 сая төгрөгийн 1 ТАХ
- Гэрээт хугацаандаа гүйцэтгэж амжаагүйгээс технологийн дагуу тухайн ажлыг дулаарахаар хийгдэхээр хойшлуулсан 295.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй 1 ТАХ;
- Гүйцэтгэлийн баримт бичгийн бүрдэл хангуулж байгаа 3,371.1 сая төгрөгийн 1 ТАХ
- Комисс ажиллуулах бэлтгэл хангуулж байна 2,415.4 сая төгрөгийн 1 ТАХ
- Гэрээний хугацаа сунгагдсан 5.131.8 сая төгрөгийн дүнтэй 4 ТАХ;

Хүснэгт 14. Гүйцэтгэгч байгууллагаас шалтгаалж гэрээний хугацаандаа дуусаагүй ТАХ

№	ТАХ нэр	Гэрээ /сая.төг/			Гүйцэтгэгч нэр	Ажлын явц
		Дүн	Эхлэх	Дуусах		
1	Хорооны цогцолбор барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 16 дугаар хороо/	1,353.1	2019.11.25 2020.09.25	2020.09.25 2020.12.25	Нэг шугам ХХК	66%
2	Инженерийн шугам сүлжээний шинэчлэлт /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 16 дугаар хороо/	1,790.0	2019.09.07	2020.09.15	Мөлүү хээр ХХК, Сагсай Өргөө ХХК-ийн түншлэл	50%
3	Сургуулийн барилгын өргөтгөл, 640 суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг, Эрдмийн өргөө цогцолбор сургууль/	3,830.9	2018.11.14 2020.01.03	2019.08.30 2020.08.03	Солид констракшн ХХК	80%
4	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 11 дүгээр хороо/	1,499.9	2019.03.28 2019.11.13	2019.11.13 2020.08.01	Дэрэн наран ХХК	79%
5	Орон сууцны байруудын дээврийн их засвар /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 8, 10, 12, 13, 14, 22 дугаар хороо/	280.3	2020.06.16 2020.08.31	2020.08.31 2020.12.10	Урал их ХХК	74%
Нийт		8,754.2				

Захиалагчийн үйл ажиллагаатай холбоотойгоор 35,135.2 сая төгрөгийн гэрээний дүнтэй 23 ТАХ гэрээний хугацаандаа хэрэгжиж дуусаагүй. Үүнд:

- Гүйцэтгэгчээс ТАХ-г гүйцэтгэж дуусгасан ч комиссын актыг баталгаажуулаагүй 17,073.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй 10 ТАХ;
- Ажлын даалгавар ирээгүй, зураг төсөв боловсруулж байгаа 479.0 сая төгрөгийн 5 ТАХ;
- Шалгарсан компани Сангийн яамнаас гаргасан хар жагсаалтад орсон 981.2 сая төгрөгийн 1 ТАХ;
- Явган хүний замын трасст өртсөн 53 -ААНБ чөлөөлөх 3,577.6 сая төгрөгийн 1 ТАХ;
- 2019-2020 онд дамжин хэрэгжиж байгаа 13,024.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй 6 ТАХ нэмэлт гэрээ, санхүүжилтээс шалтгаалан хугацаандаа хэрэгжээгүй.

Гүйцэтгэгч хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг зураг төслийн дагуу гэрээний хугацаанд үр дүнтэй гүйцэтгэсэн эсэхийг 2020 онд хэрэгжиж дууссан 41,888.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй 73 ТАХ-ээс 28,208.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй 40 ТАХ буюу 54.7%-ийг аудитын түүвэрт хамруулан тулган баталгаажуулалт хийхэд зарим зөрчил илэрч байна. Үүнд:



“НХОГ” ОНӨААТҮГ -аас захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ТАХ:

- Цэцэрлэгийн барилгыг буулгаж, шинээр барих, 240 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 28 дугаар цэцэрлэг/ Гүйцэтгэгч “Морин сувд” ХХК. Гэрээний дүн: 2,928.1 сая төгрөг. ТАХ-г 2019 оны 10 сард 2019/492 тоот актаар улсын комисс хүлээн авсан. Барилгын зураг төсөлд биеийн тамир, хөгжмийн танхимыг БНБД-II-66-68²⁵-д заасны дагуу байгалийн гэрэлтүүлэг тусахаар саруулхан том цонхтой, агаар солилцох салхивчтай байхаар байхад цонх нь жижиг гэрэлтүүлэг болон агаар сэлгэлт муу өрөө тасалгаанд сургалт хүмүүжлийн ажил явуулж байна;
- Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 189 дүгээр цэцэрлэг “Морин сувд” ХХК. Гэрээний дүн: 1,800.0 сая төгрөг. Гадна цэвэр усны шугамын халаалтын кабель ажиллагаагүй тасарсан, бохир усны гаргалгаа худагт дулаалгатай таг хийгдээгүй, ангиудын угаагуур, суултуур эвдэрсэн, холигч уян холбоос муудсан, гал тогооны утаа сорогчийн цахилгааны утас холбогдоогүй;
- Цэцэрлэгийн барилга 150 ор худалдан авах /УБ хот, БЗД, 6-р хороо/ Уг ТАХ-ний ХАА-г зохион байгуулах эрх НЗД-ын 2019.03.18-ний А/199 дугаар захирамжаар НХААГ-т эрх шилжсэн. НХААГ-ын даргын 2019.05.02-ны өдрийн А/55 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо зохион байгуулсан. Гүйцэтгэгч “ТЭТҮ ХХК” барилга угсралт, зураг төслийн байгууллага. Гэрээний дүн: 2,490 .0 сая төгрөг.

Уг ТАХ нь Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын орчны стандарт, МХЕГ-ын даргын 2017 оны “Үлгэрчилсэн дүрэм батлах тухай” А/179 дүгээр тушаалын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Сургалт-хүмүүжлийн байгууллагад мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм” -ийн 2.4²⁶, 2.5²⁷, 2.9²⁸, 3.6²⁹-д тусгагдсан сургалт-хүмүүжлийн барилга байгууламжийг хөдөлгөөн, дуу шуугиан ихтэй гудамж, утаа, тортгийн эх үүсвэрээс 500-аас доошгүй метр, газарт барьж байгуулах, өөрийн эдэлбэр газартай байх, эргэн тойронд бут, сөөг тарьж ногоон байгууламж байгуулах ба нийт талбайн 50-иас доошгүй хувийг зүлэгжүүлэн-мод тарьж, 50 хүртэлх хувийг цардаж зассан байх, эдэлбэр газартай байх /хичээллэх биеийн тамир спортын, амрах, аж ахуйн/, сургуулийн өмнөх насны хүүхдийн барилгын давхрын дээд хязгаар 2 давхар байх зэрэг шаардлагыг хангахгүй байна. Тухайлбал уг барилга нь амины орон сууцны зориулалтай, 3 болон 4 давхартаа анги танхим хуваарилсан, стандарт шаардлага хангасан эдэлбэр газаргүй, анги танхим, ариун цэврийн өрөөний талбайн хэмжээ бага, анги танхимууд байнгын нар үздэггүй хойд зүг харсан цонхнуудтай зэрэг цэцэрлэгийн барилгад тавигдах энгийн шаардлагуудыг хангаагүй байна.

Иймд илэрсэн зөрчлүүдийг давтан гаргахгүй байх талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд хугацаатай албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Дүгнэлт: Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагууд зарим ТАХ-ний гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангуулаагүй байна.

²⁵ Сургалт хүмүүжлийн барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах норм дүрэм БНБД -II-66-68-д “хөгжмийн танхим байгалийн гэрэлтүүлэг тусахаар саруулхан том цонхтой, агаар солилцох салхивчтай байна”

²⁶ 2.4. Сургалт-хүмүүжлийн барилга байгууламжийг хөдөлгөөн, дуу шуугиан ихтэй гудамж, төмөр зам, үйлдвэрийн дуу шуугиан, химийн хорт бодис, хорт хий, утаа, тортог, цацраг тоос болон бусад бохирдуулж болох эх үүсвэрээс 500-аас доошгүй метр, үйлдвэр, ахуйн хатуу, шингэн хог хаягдлаас 200 метрээс доошгүй зайд үер, гал, усны аюулд өртөхөөргүй газарт барьж байгуулна. Сургуулийн барилгыг гэрэл сайн тусахаар урагшаа буюу зүүн урагш харуулан барина.

²⁷ 2.5. Сургалт хүмүүжлийн байгууллага нь өөрийн эдэлбэр газартай байна. Эдэлбэр газрын эргэн тойронд бут, сөөг тарьж ногоон байгууламж байгуулах ба нийт талбайн 50-иас доошгүй хувийг зүлэгжүүлэн, мод тарьж, 50 хүртэлх хувийг цардаж зассан байна. Модыг барилгын цонхноос 10 м-ийн зайд, бут, сөөгийг 5 м-ээс доошгүй зайтай тарьж суулгана.

а/ Сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллага: 150 хүртэл суудалтай-Сургалт- хүмүүжлийн байгууллагын эдэлбэр газар Хичээллэх Биеийн тамир спортын, амралтын, аж ахуйн.

²⁸ 2.9. Барилгын давхрын дээд хязгаарыг хүснэгт 3-д заасны дагуу тогтооно.

²⁹ Сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллага 2 давхар

3.6. Сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллагын барилга, байгууламжийн агаар солилцооны давтамж, агаарын тооцооны температурыг хүснэгт 6-д заасны дагуу төлөвлөнө.



Б.2.2. Захиалагч, зохиогч, мэргэжлийн байгууллагын хяналтаар илэрсэн зөрчлийг гүйцэтгэгчээр тухай бүрд нь арилгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн үү?

Аудитаар 2020 онд хэрэгжүүлсэн 88,849.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй 83 ТАХ-г хэрэгжүүлэх явцад захиалагч, зураг төсөв зохиогч, холбогдох мэргэжлийн байгууллагууд хяналт хэрхэн тавьсан, гүйцэтгэгч илэрсэн зөрчил дутагдлыг хугацаанд биелүүлсэн эсэхийг талбайн журнал болон холбогдох бусад баримт материалын хүрээнд тулган баталгаажуулав.

Барилга байгууламжийн талбайн журналд тэмдэглэгдсэнээр ТАХ-ний хэрэгжилтийн явцад НХОГ-ийн инженерүүд, зураг төсөв зохиогч нар аас хөдөлмөр хамгааллыг сахиж ажиллах, үе шатны ажлыг технологийн дагуу хугацаанд нь гүйцэтгэх, дутуу болон чанаргүй хийгдсэн ажлыг дахин хийх, үе шатны ажлыг гүйцэтгэж дуусахад актуудыг холбогдох албан тушаалтнуудаар заавал баталгаажуулж байх, сорьц дээж авч лабораторид туршилт хийлгүүлэх гэх мэт үүрэг даалгавар зөвлөмжийг өгч ажилласан байна.

Гүйцэтгэгчдээс өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлснээр ил далд ажлын актыг цаг тухай бүр захиалагч, зохиогч нараар баталгаажуулсан, ажлын гүйцэтгэл, ил болон далд ажлуудыг фото зургаар баталгаажуулж хэвшсэн байна.

Мөн графикт ажлыг хугацаанд нь гүйцэтгэх, гэрээнд заасан хугацаанд багтаан дуусах зэрэгт ахиц гарсан байна. Тухайлбал: 2020 онд 83 ТАХ хэрэгжиж дуусгах гэрээ байгуулснаас захиалагчаас шалтгаалж хугацаандаа дуусаагүй 31 ТАХ байгаа бол гүйцэтгэгчээс шалтгаалсан 13 ТАХ байна.

Дүгнэлт: Илэрсэн зөрчлийг гүйцэтгэгчээр тухай бүрд нь арилгуулах арга хэмжээг авч, тодорхой үр дүнд хүрсэн байна.

Б.2.3. Хөрөнгө оруулалтаар авсан тоног төхөөрөмж хууль, эрх зүйн баримт бичигт туссаны дагуу хэрэглэгчдэд бүрэн хүрсэн үү?

2020 онд хэрэгжиж дууссан 28,208.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй 40 ТАХ-г аудитын түүвэрт хамруулан хөрөнгө оруулалтаар авсан тоног төхөөрөмж хууль, эрх зүйн баримт бичигт туссаны дагуу хэрэглэгчдэд бүрэн хүрсэн эсэхийг газар дээр нь очиж тулган баталгаажуулалт хийхэд тоног төхөөрөмж хэрэглэгчдэд бүрэн хүрсэн байна. Тухайлбал:

- “Констрашн инженеринг энд консалтинг сервес” ХХК-ийн Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-т нийлүүлсэн ус зөөврийн 3 ширхэг автомашин хэрэглэгчдэд үйлчилж байна.
- “Сүлдэт жороо” ХХК-ийн нийлүүлсэн компьютер тоног төхөөрөмж баримт бичигт туссаны дагуу сургууль, цэцэрлэгт бүрэн хүрч ашиглагдаж байна.
- “Төгс хурц консалтинг” ХХК-ийн СХД-ийн 18,19, 23, 27, 29, 39 дүгээр хороодод нийлүүлсэн тавилга,эд хогшил, тоног төхөөрөмж, баримт бичигт туссаны дагуу хороодод хүрсэн байна.
- “Саннилайф” ХХК-ийн СХД-ийн 3 сургууль, 8 цэцэрлэгт нийлүүлсэн компьютер тоног төхөөрөмж тоног төхөөрөмж эрх зүйн баримт бичигт туссаны дагуу чанар үзүүлэлтийг хангасан, хэрэглэгчдэд бүрэн хүрч, ашиглаж байна.

Харин чанарын шаардлага хангаагүй, хэрэглэгчийн зүгээс гомдол бүхий зөрчилтэй зарим ажлууд байна. Тухайлбал:

- “Саммит компьютер технологи” ХХК-ийн БГД-ийн 19, 20, 38,51, 73,141 дугаар сургуулиудад нийлүүлсэн компьютер тоног төхөөрөмж зохих хэрэглэгчдэд хүрсэн ч зарим тоног төхөөрөмж чанар багтаамж тааруу, хүчин чад ал муугаас ашиглахад хүндрэл үүссэн байна.



- “Зүүн-Алдар ХХК”-ийн Нийслэлийн Соёл, урлагийн газарт нийлүүлсэн тавилга, компьютер тоног төхөөрөмжийг тоолж тулган баталгаажуулалт хийхэд Даргын өрөөний иж бүрэн тавилгын хийц, нэр төрөл, тоо хэмжээ нь өөрчлөгдсөн, үнэлгээ байхгүй зэрэг зөрчил байна.

Дүгнэлт: Хөрөнгө оруулалтаар авсан тоног төхөөрөмж техникийн тодорхойлолтод заасны дагуу хэрэглэгчдэд хүрсэн ч чанарын шаардлага хангаагүй ашиглахад хүндрэлтэй байна.

Б.2.4. Гүйцэтгэгч төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан уу?

2020 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 141 ТАХ-д 81,379.0 сая төгрөгийн санхүүжилтийг захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагаар дамжуулан Сангийн яамнаас олгожээ.

Үүнээс аудитаар “НХОГ” ОНӨААТҮГ-аар гүйцэтгэлээ хянуулан 75,661.5 сая төгрөгийн санхүүжилт авсан 102 ТАХ-ээс түүвэрлэн үзэхэд 3 ТАХ-ний санхүүжилт болох 704.3 сая төгрөгийг “НХОГ” ОНӨААТҮГ-ын барьцаа дансанд байршуулсан нь Төсвийн тухай хуулийн 7.7³⁰, 43.5³¹, 45.2³²-д заасан төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлэх заалтыг зөрчиж байна. Үүнд:

- Орон сууцын фасад, дээврийн их засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 3 дугаар хороо, “Ганжигүүр” СӨХ, 43, 45 дугаар байр/, гэрээний дүн 131.5 сая төгрөг, барьцаанд 129.2 сая төгрөг;
- “Боловсрол” цогцолбор сургуулийн барилгын их засвар /Улаанбаатар, Багануур дүүрэг/, гэрээний дүн 249.9 сая төгрөг, барьцаанд 230.3 сая төгрөг;
- Чойжин ламын сүм музейн дээвэр, сантехник, цэвэр усны шугам сүлжээний засварын ажил /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, Чойжин ламын сүм музей/, гэрээний дүн 344.8 сая төгрөг, барьцаанд 344.8 сая төгрөгийг тус тус байршуулжээ.

НЗДТГ-аас хөрөнгө оруулалтаар олгосон санхүүжилтийн мэдээг ирүүлэхдээ гүйцэтгэгч байгууллагад олгосон дүн, захиалагчийн хяналтын зардалд олгосон дүн, барьцаа дансанд байршуулсан дүн зэргийг гаргаж ирүүлээгүй нь олгосон санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан эсэхэд бүрэн дүгнэлт, зөвлөмж өгөх боломжгүй байдалд хүргэж байна.

Мөн 2020 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэгчид олгосон санхүүжилтэд Нийслэлийн дотоод аудитын газар явцын хяналт шалгалтыг хийгээгүй байна.

Дүгнэлт: Нийслэлийн төрийн сангаар дамжуулан олгосон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 141 ТАХ-д 81,379.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгожээ.

³⁰ Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ.

³¹ Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй.

³² Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ.



Б.3. ТАХ-ний гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн үү?

Б.3.1. ТАХ-ний хэрэгжилтэд тавих захиалагчийн болон зохиогчийн хяналтын үр ашигтай тогтолцоог бүрдүүлж, үе шатны хяналтыг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлж, баталгаажуулсан уу?

ЗГ-ын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга захиалагчийн дүрэм”-ийн 2.2³³-т захиалагчийн чиг үүрэг хэрэгжүүлэх этгээдийг байнгын ажиллагаатай, эсхүл тухайн барилга байгууламжийн барилгын ажил гүйцэтгэх хугацаагаар байгуулан ажиллуулж болохоор заажээ. Нийслэлд хэрэгжиж байгаа ТАХ, үүний дотор авто зам, гүүр, барилга, байгууламжийн хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий НАЗХГ /дүрмийн 3.2³⁴/, “НХОГ” ОНӨААТҮГ /дүрмийн 4.3.1³⁵/, хэрэгжүүлж байна.

Аудитад 2020 онд хэрэгжиж дууссан 28,208.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй 40 ТАХ-г хамруулан газар дээр нь очиж тулган баталгаажуулалт хийсэн.

Эдгээр ТАХ-ний захиалагчийн хяналтыг дараах газруудаас хэрэгжүүлжээ. Үүнд:

- УБ хотын ЗАА 1,754.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй 5 ТАХ;
- НБГ-аас 1,497.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй 8 ТАХ;
- НМТГ-аас 10.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй 1 ТАХ;
- НӨАУГ-аас 628.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй 3 ТАХ;
- НСУГ-аас 50.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй 1 ТАХ;
- “НХОГ” ОНӨААТҮГ-аас 24,270.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй 23 ТАХ-нд тус тус хэрэгжүүлсэн байна.

Захиалагчаас барилга байгууламжийн ажлын хүрээнд ЗГ-ын 2017 оны 170 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 3.9³⁶-д заасны дагуу үе шатны ажилд хяналт хэрэгжүүлэхдээ холбогдох ил далд ажлын акт, баримт материал, графикт хугацаа, гэрээний дагуу хянаж баталгаажуулсан байна.

Мөн ил далд ажлын актууд, үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэлүүд, холбогдох бусад баримт бичгийг үндэслэж байна. Дээрх туршилт тохируулга хийсэн болон ил далд ажлын актыг холбогдох албан тушаалтнууд /захиалагч, зохиогч, гүйцэтгэгчийн төлөөлөл, инженерүүд / тухай бүр баталгаажуулж ирсэн байна.

Ажил гүйцэтгэх явцад үе шатны ажлын технологийн дарааллын дагуу холбогдох баримт бичиг, барилгын ажил гүйцэтгэх төлөвлөгөө, график, санхүүжилт зэргийг тухай бүр хянан баталгаажуулсан байна.

Дүгнэлт: ТАХ-ний хэрэгжилтэд тавих үе шатны хяналтыг хугацаанд нь хэрэгжүүлж, баталгаажуулсан байна.

³³ 2.2.Барилга байгууламжийн хөрөнгө оруулагч захиалагчийн чиг үүрэг хэрэгжүүлэх этгээдийг байнгын ажиллагаатай, эсхүл тухайн барилга байгууламжийн барилгын ажил гүйцэтгэх хугацаагаар байгуулан ажиллуулах бөгөөд Барилгын тухай хуулийн 37.2-т заасан мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх этгээдээр захиалагчийн чиг үүргийг төлөөлүүлэн хэрэгжүүлж болно.

³⁴ 3.2. нийслэлийн авто замын салбарт хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хүрээнд ав то зам, замын байгууламжийг шинээр барих, өргөтгөн шинэчлэх, урсгал засвар, ашиглалт, арчлан хамгаалалтын ажлыг зохион байгуулж, захиалагчийн болон лабораторийн хяналт тавих, ашиглалтад хүлээлгэн өгөх;

³⁵ 4.3.1-т үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үндсэн чиглэл нь улс, нийслэлийн төсөв, гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламжийн хөрөнгөөр барилга байгууламж шинээр барих, өргөтгөх, шинэчлэн засварлах үйл ажиллагаанд гэрээний үндсэн дээр хяналт тавих

³⁶ 3.9.Захиалагч үе шатны ажилд техникийн хяналт тавих, гүйцэтгэлийн тэмдэглэл, ил далд ажлын болон тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохируулга хийсэн акт, санхүүжилтийн тооцоо, холбогдох бусад баримт бичгийг барилгын ажил гүйцэтгэх график, гэрээний дагуу барилгын үйл ажиллагаанд оролцогчтой хамтран хянаж, баталгаажуулахаас гадна техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээдтэй хамтарсан үзлэг шалгалтыг урьдчилан сэргийлэх зорилгоор тухай бүр хийсэн байна.



Б.3.2. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн, хугацаанд нь бүрэн олгосон уу?

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд нийслэлд нийт 291,696.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 189 ТАХ хэрэгжсэнээс 125 ТАХ-д 81,379.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Хүснэгт 15 . 2020 онд ТЕЗ-аас нийслэлээр дамжин санхүүжүүлсэн дүн

№	ТЕЗ	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	2020 онд санхүүжих дүн	Гэрээний үнийн дүн	/сая.төг/ 2020 онд олгосон дүн
1	МУЕС	1	4,000.0	800.0	3,685.9	800.0
2	БОАЖС	2	3,847.0	1,447.0	3,796.4	1,424.6
3	БШУСС	66	151,626.6	62,901.6	139,531.2	49,985.9
4	БХБС	100	79,501.3	25,416.6	70,007.2	16,820.6
5	ЗГХЭГД	6	5,444.0	1,344.0	5,413.2	834.4
6	СоёлС	2	9,500.0	4,750.0	9,483.3	4,750.0
7	ХХААХҮС	2	3,100.0	937.0	2,991.2	616.8
8	ЭХС	2	30,937.3	4,000.0	4,000.0	4,000.0
9	ЭМС	8	3,740.0	2,150.0	3,700.5	2,146.7
	Нийт	189	291,696.2	103,746.2	242,609.0	81,379.0

“НХОГ” ОНӨААТҮГ-аас захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн 200,402.4 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 96 ТАХ -д 75,661.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосноос 2,553.8 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 5 ТАХ -д бодит гүйцэтгэлд үндэслээгүй 1,418.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагын хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулсан байна.

Хүснэгт 16 . Гүйцэтгэлд үндэслээгүй олгосон санхүүжилтийн задаргаа

№	Барилга байгууламж, их засварын ажлын нэр, хүч чадал, байршил	Батлагдсан төсөвт өртөг	2020 онд санхүүжих	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт
1	Хүүхдийн тоглоомын талбай /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 6 дугаар хороо/	100.0	100.0	93.2	26.6
2	Орон сууцны фасад, дээврийн их засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 3 дугаар хороо, "Ганжигүүр" СӨХ, 43, 45 дугаар байр/	132.0	132.0	131.5	129.2
3	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 10 дугаар хороо/1	1,750.0	950.0	1,734.3	687.6
4	"Боловсрол" цогцолбор сургуулийн барилгын их засвар /Улаанбаатар, Багануур дүүрэг/	250.0	250.0	249.9	230.3
5	Чойжин ламын сүм музейн дээвэр, сантехник, цэвэр усны шугам сүлжээний засварын ажил /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, Чойжин ламын сүм музей/	350.0	350.0	344.8	344.8
	Нийт	2,582.0	1,782.0	2,553.8	1,418.5

Харин 2020 онд бүрэн хэрэгжиж дууссан 3,002.8 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 17 ТАХ-д 1,323.5 сая төгрөгийг санхүүжилтийг төсөвт тодотгол хийгдсэнээс шалтгаалж гүйцэтгэгчид дутуу олгожээ. Хавсралт 6

Дүгнэлт: ТАХ-ний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээр олгоггүй, ЗГ-ийн шийдвэрийн хүрээнд барьцаа дансанд байршуулсан байна.

Б.3.3. Хөрөнгө оруулалтын үйл явцад тавих Засгийн газрын болон ТЕЗ -ын дотоод хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?

Төсвийн тухай хуулийн 69.1³⁷-д ТЕЗ нь төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт

³⁷ 69.1.Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.



хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, ажиллуулах талаар тусгасан.

НЗД-ын 2014 оны А/156 дугаар захирамжаар Дотоод аудитын газрыг байгуулж, 2019 оны А/349 дүгээр захирамжаар дүрмийг нь шинэчлэн баталжээ.

Нийслэлийн Дотоод аудитын газрын 2020 оны аудит, хяналт шалгалтын төлөвлөгөөнд улсын төсвөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний барилга байгууламжийн техникийн хяналтын байдалд Сангийн яамтай хамтарсан шалгалт хийхээр тусгасан байна.

Сангийн сайдын 2020 оны 04 дүгээр сарын 8-ний өдрийн “Улсын төсвөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний барилга байгууламжийн захиалагчийн техник хяналтын үйл ажиллагаа, түүний үр дүнд эрсдэлд суурилсан дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийх удирдамж батлагдсан ч сангийн яамнаас уг шалгалтад Нийслэлийн Дотоод аудитын газрыг татан оролцуулаагүй байна.

ТАХ-ний хэрэгжилтийн явц, үр дүнд дотоод хяналт хийгдээгүйгээс ТАХ -ээг хэрэгжүүлэх явцад хууль, дүрэм зөрчигдөх, төсвийн хөрөнгө арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулагдах зэрэг нөхцөлүүд үүсэх үр д агавартай байна.

Дүгнэлт: Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй ТАХ -ний хэрэгжилтийн явц болон үр дүнд тавих дотоод хяналтыг зохион байгуулаагүй байна.

Б.4 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын тухайн жилд батлагдсан санхүүжилтийг бүрэн ашиглах зорилгоор Засгийн газраас гаргасан шийдвэр үр дүнтэй байна уу?

Б.4.1. Засгийн газраас ТЕЗ-ийн барьцаа хөрөнгийн данс болон урьдчилгаа төлбөрийн баталгаагаар олгосон төсөл, арга хэмжээний санхүүжилт үр дүнтэй байна уу?

ТБОНӨХБАУХАТ Х-ийн 43.6-д бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаат болон зүгшрүүлэх тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг уг хугацаа дуустал барьцаалах нөхцөлийг захиалагч тендерийн баримт бичигт тусгаж болно гэж заасан. Энэ заалтын дагуу захиалагч нь дууссан ТАХ-ний хувьд тодорхой хэмжээний хөрөнгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулан авч үлддэг.

Гэтэл ЗГ-ын 2020 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай 253 дугаар тогтоолын 1.2-д тусгагдсаны дагуу зарим зайлшгүй ТАХ-ний санхүүжилтийг ТЕЗ-ын барьцаа хөрөнгийн дансанд байршуулахыг ТЕЗ нарт даалгасан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд нийт 141 ТАХ-д 81,379.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосноос НХОГ-аас захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн 200,402.4 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 102 ТАХ-д 75,661.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгожээ. Үүнээс 49,368.0 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 45 ТАХ-д 27,029.7 сая төгрөгийн санхүүжилт олгосноос 6,733.7 сая төгрөгийн хөрөнгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулжээ.

Үүнээс гэрээний үнийн дүнгийн 10 -аас дээш хувийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан 23,560.2 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 17 ТАХ байгаагаас бүрэн хэрэгжиж дуусаагүй 10,230.4 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 16 ТАХ байна.



Хүснэгт 17. Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан хөрөнгийн дүн

/сая.төг/

№	Барилга байгууламж, их засварын ажлын нэр, хүч чадал, байршил	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт	Үүнээс барьцаа дансанд байршуулсан	Гэрээний дүнд эзлэх барьцааны хувь	Гүйцэтгэгчийн нэр
1	Гэр хорооллын гэрэлтүүлэг	59.5	58.0	7.1	12	Хануй-Энержи ХХК
2	Хүүхдийн тоглоомын талбай	295.4	290.3	55.5	19	Хүчит аргун ХХК
3	Хүүхдийн тоглоомын талбай	93.2	26.6	26.6	29	Инсталлнарн н констракшн ХХК
4	Нийтийн эзэмшлийн орон сууцуудын гадна талбайн тохижилт	398.3	391.6	209.4	53	Буяннэмэх интер ХХК
5	Орон сууцын фасад, дээврийн их засвар	131.5	129.2	129.2	98	Төмөрт хос бэрс ХХК
6	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга	3,371.1	1,409.7	527.4	16	Адамант ХХК
7	Сургуулийн барилга буулгаж, шинээр барих, 640 суудал	4,877.2	2,349.4	570.1	12	Гэрэлтжин ХХК
8	Цэцэрлэгийн барилга, 150 ор	1,734.3	687.6	687.6	40	Түшигдаян оргил ХХК
9	Цэцэрлэгийн барилга, 240 ор	2,335.8	1,835.8	284.8	12	Баганат өргөө ХХК
10	Цэцэрлэгийн барилга, 150 ор	1,790.0	858.9	249.0	14	Мета менежмент ХХК
11	Цэцэрлэгийн барилга, 280 ор	2,698.0	1,298.0	833.1	31	Жамъяан пайтан ХХК
12	Сургуулийн барилгын өргөтгөлийн үлдэгдэл санхүүжилт /хэрэгжсэн/	486.1	477.7	65.2	13	Бумбод ХХК
13	Сургуулийн спорт заалын өргөтгөлийн барилга	1,050.4	714.9	253.8	24	Мета менежмент ХХК
14	"Боловсрол" цогцолбор сургуулийн барилгын их засвар	249.9	230.3	230.3	92	СНТ групп ХХК
15	Сургуулиудын гараж, засвар, тохижилт	287.1	220.0	156.0	54	Ньюсиндкат ХХК
16	Шинжлэх ухааны академийн нэгдсэн байрын өргөтгөлийн барилга	3,357.6	1,998.7	510.2	15	Хөх бүрдний эх ХХК
17	Чойжин ламын сүм музейн дээвэр, сантехник, цэвэр усны шугам сүлжээний засварын ажил	344.8	344.8	344.8	100	Их Очирт хүрдэн ХХК
Нийт		23,560.2	13,321.4	5,140.1		

Дээрх байдлаар тухайн жилд зарцуулагдаагүй санхүүжилтийн үлдэгдлийг барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 7.7³⁸, 43.5³⁹, 45.2⁴⁰-д заасан төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлэх, ТБОНӨХБАҮХАТХ-д заасан барьцаа хөрөнгийн дансанд гэрээний үнийн дүнгийн 5 -10%-ийг байршуулж болох заалтуудыг зөрчиж байна.

Дүгнэлт: ЗГ-ын тогтоолын дагуу зарим ТАХ-ний санхүүжилтийн үлдэгдлийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан нь Төсвийн тухай хуулийн 7.7, 43.5, 45.2 дах заалтуудыг зөрчиж байна.

³⁸ Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ.

³⁹ Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй.

⁴⁰ Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ.



Б.4.2 2020 онд ашиглалтад орсон барилга байгууламж, хүлээн авсан тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг бүртгэлд тусгаж, бүрэн хүчин чадлаар нь ашиглаж байна уу?

Нийслэлийн ИТХТ-ийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулах журам”-ын 3.1⁴¹-т заасны дагуу хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг төсөл хэрэгжсэн хуулийн этгээдийн тайлан баланст бүртгэдэг байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалта ар 2020 онд хэрэгжих ТАХ-ээс НӨАХУГ-т 43,654.1 сая төгрөгийн өртөг бүхий 77, ашиглагч байгууллагуудад бүртгэх 3,101.0 сая төгрөгийн өртөг бүхий 21, өмчид бүртгэгдэхгүй хөрөнгө оруулалтын бус шинж чанартай 8,222.0 сая төгрөгийн өртөг бүхий 13, 2021 он руу дамжин хэрэгжих 43,479.0 сая төгрөгийн 80 ТАХ байна.

НӨАУГ-т бүртгэгдэх 77 ТАХ-ээс 2,637.2 сая төгрөгийн өртөг бүхий 12 ТАХ нь бүртгэгдсэн, 65 ТАХ-ний холбогдох баримт материалыг захиалагч ирүүлээгүйгээс бүртгэгдээгүй байна. Хавсралт 7.

Бусад ажлуудын хувьд баримт бичгийн бүрдүүлбэрийг хангуулах, хянах, холбогдох зөвшөөрөл авах, тогтоол гаргах зэргээр 2021 онд бүртгэгдэхээр байна.

Нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж, ашиглалтад хүлээн авсан барилга байгууламжийн ашиглалтын байдалтай газар дээр нь танилцахад бүрэн хүчин чадлаар нь ашиглах боломжгүй зарим зөрчил илэрч байна. Үүнд:

- Хог тээврийн автомашин /Улаанбаатар, Баянгол дүүрэг. 1, 3 дугаар хороо/. Гэрээний дүн: 290.0 сая төгрөг. Гүйцэтгэгч “Бадрангуй орших” ХХК. Тус дүүргийн Тохижилт үйлчилгээний байгууллагуудад нийлүүлсэн БНХАУ-д 2020 онд үйлдвэрлэсэн Dongfeng Dfac маркийн хог тээврийн 2 ширхэг шинэ автомашин 4 сар ашиглагдаад эвдэрсэн, чанарын болон ашиглалтын шаардлага хангаагүй.
- Тендерийн үнэлгээний хороо тендерийн баримт бичигт технологийн бүрдүүлбэрийг дутуу боловсруулан компьютерын дэлгэцийг тусгаагүйгээс СХД-ын ЕБС-ийн 153,143, 62, 12 дугаар сургуулиудад “Сод электроникс” ХХК-ийн нийлүүлсэн 42 компьютер ашиглалтгүй байна.
- “Саммит компьютер технологи” ХХК-ийн БГД-ийн 19, 20, 38,51, 73, 141 дугаар сургуулиудад нийлүүлсэн компьютер, тоног төхөөрөмжийн багтаамж тааруу, хүчин чадал муугаас ашиглалт нь хангалтгүй байна.
- БГД-ын 10 дугаар хорооны цогцолбор барилга баригдаагүйгээс нийлүүлэгдсэн 197.7 сая төгрөгийн өртөг бүхий техник тоног төхөөрөмж хадгалалтын шаардлага хангаагүй, харуул хамгаалалт муутай газар хадгалж байсныг аудитын явцад зөвлөж БГД-ын 20 дугаар хороонд байрлах архивын байранд шилжүүлэн харуул хамгаалалттай болгосон.
- Газрын асуудлыг бүрэн шийдвэрлээгүйгээс “Бүрэн одод” ХХК-ийн хэрэгжүүлсэн Агропаркийн эко сургалтын төвийн барилга нь цэвэр усны хамгаалалтыг бүсэд баригдаж сургалтын төвийн зориулалтаар бүрэн хүчин чадлаар нь ашиглахад хүндрэл үүссэн байна.

Дүгнэлт: Ашиглалтад орсон барилга байгууламж, хүлээн авсан тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг бүртгэлд тусгах ажил хийгдсэн байна. Чанарын шаардлага хангаагүй хөрөнгө нийлүүлснээс шалтгаалж зарим техник тоног төхөөрөмжийн ашиглалт нь хангалтгүй, бүрэн хүчин чадлаар нь ашиглах боломжгүй байна.

⁴¹ “Улс нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаад, дотоодын гадаад дотоодын зээл төсөл хөтөлбөр, буцалтгүй тусламж, хандив, бэлэглэлийн хөрөнгөөр бий болсон барилга байгууламж, их засварын ажил, худалдан авсан тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгийг тухайн төсөл хэрэгжүүлсэн хуулийн этгээдийн тайлан балансад бүртгэнэ”



АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

1. Газрын зөвшөөрөлгүй, зураг төсөвгүй, техникийн нөхцөлгүй ТАХ -г төлөвлөдөг, он дамжин хэрэгжих ажлын санхүүжилтийг дутуу тооцож батлуулсан зэрэг нь төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн гарах хугацааг удаашруулж байна.
2. ТАХ-ний эрхийг хугацаанд нь шилжүүлээгүйгээс шалтгаалж ХАА зохион байгуулах ажил хойшлогдох, тухайн онд хэрэгжих боломжгүй болох зэргээр ТАХ-ний үр дүн, үр ашигт сөргөөр нөлөөлж байна.
3. ХАА зохион байгуулах явцад илэрсэн зөрчил нь ХАА-ны өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг алдагдуулж байна.
4. ЗГ-ын тогтоолын дагуу зарим ТАХ-ний санхүүжилтийн үлдэгдлийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан нь Төсвийн тухай хуулийн 7.7, 43.5, 45.2 дах заалтуудыг зөрчиж байна.
5. ТАХ-ний зохион байгуулалт, хэрэгжилтэд тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс шалтгаалж нийлүүлэгдсэн техник тоног төхөөрөмжийн ашиглалт нь хангалтгүй, зарим сургууль, цэцэрлэгийн барилгуудад холбогдох эрх зүйн шаардлага болон сургуулийн өмнөх боловсрол ын байгууллагын сургалтын орчны стандарт бүрэн мөрдөгдөхгүй байна.



АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч /Д.Сумъяабазар/-д:

1. ТЕЗ-аас шилжин ирсэн ТАХ-г шуурхай зохион байгуулах; /Эрхийг мэргэжлийн байгууллагад нь шилжүүлэх/
2. ТАХ-ний санхүүжилтийн үлдэгдлийг барьцаа хөрөнгийн дансанд Засгийн газрын тогтоолд заасны дагуу байршуулах;
3. ТАХ-ний худалдан авалт, гүйцэтгэлтэй холбоотой зөрчил арилахгүй жил бүр давтагдаж байгаад анхаарал хандуулж сонгон шалгаруулсан, захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн, ашиглалтад хүлээн авсан байгууллага, комисс, албан тушаалтан, төрийн албан хаагчдын ажлын хариуцлагыг сайжруулж, зөрчлийг цаашид дахин гаргахгүй байх;
4. Эрх шилжүүлсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа ТАХ-д тавих захиалагчийн хяналтыг сайжруулах.

НХААГ, дүүргүүдийн ХААА -нд:

1. Тендерт оролцогчдоос ирүүлсэн баримт, материалыг үнэн зөвөөр үнэлэх, шаардлага хангасан гүйцэтгэгч сонгон шалгаруулах, ХАА-ны явцад тавих хяналтыг сайжруулан, өрсөлдөх тэгш боломжоор хангаж, ХАА -ны үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг хэрэгжүүлж ажиллах;
2. Тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх талаар холбогдох байгууллагуудыг зөвлөгөө, мэдээллээр бүрэн хангаж, биелэлтэд хяналт тавих.

“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ -т:

1. Сургууль, цэцэрлэгийн барилга угсралтын явцад тавих захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй, ажлыг дутуу болон чанаргүй гүйцэтгүүлсэн зөрчлийг арилгаж, стандартын шаардлагад нийцүүлэн засуулж, давтан гаргуулахгүй ажиллах.

Үндэсний аудитын газарт санал хүргүүлэх тухай:

